

БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН НЭГТГЭЛИЙН ТАНИЛЦУУЛГА

2022 оны III улирлын санхүүгийн тайлан

БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГЫН ГАЗАР

Монгол Улс, Улаанбаатар хот 15160, Чингэлтэй Дүүрэг, Бага тойруу 3, Засгийн газрын
IV байр. Утас: 51-261668 Цахим шуудан: nbfi@frc.mn

Агуулга

Хүснэгтийн жагсаалт.....	3
Зургийн жагсаалт.....	3
Товчилсон нэрсийн жагсаалт	4
Банк бус санхүүгийн байгууллагын салбарын ерөнхий төлөв байдал.....	5
Хууль, тогтоомж болон журмын өөрчлөлт, хэрэгжилт	7
“Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай” хуулийн 15 дугаар зүйлийн 15.4 дэх заалтын хэрэгжилт.....	7
“Зээлийн мэдээллийн тухай” хуулийн хэрэгжилт.....	7
“Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай” хуулийн хэрэгжилт ..	7
“Зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээг тогтоох, төвлөрүүлэх журам”-ын хэрэгжилт	8
Статистик үзүүлэлтүүд	9
Харилцагчид, зээлдэгчид.....	9
Хувьцаа эзэмшигчид болон ажилчид	9
Тархалт	10
Активын бүтэц, бүрэлдэхүүн, өөрчлөлт.....	11
Мөнгөн хөрөнгө.....	12
Богино хугацаат хөрөнгө оруулалт.....	12
Факторингийн тооцооны авлага.....	13
Өмчлөх бусад үл хөдлөх болон өмчлөх бусад хөрөнгө	13
Зээл.....	13
Цахим зээл.....	16
Ногоон зээл	17
Бусад хөрөнгө	19
Эргэлтийн бус хөрөнгө	19
Пассивын бүтэц, бүрэлдэхүүн, өөрчлөлт	20
Санхүүгийн эх үүсвэр	20
Дотоод, гадаадын банк, санхүүгийн байгууллагад төлөх өглөг	21
Бусад эх үүсвэр	21
ББСБ-аас гаргасан өрийн бичиг	22
Төслийн зээлийн санхүүжилт.....	23
Бусад өр төлбөр	23
Хувь нийлүүлсэн хөрөнгө.....	24
Бусад өмч, сангууд	25
Хуримтлагдсан ашиг	25
Хоёрдогч өглөг.....	25
Ашигт ажиллагаа	26
Гадаад валют арилжааны мэдээ	28
Зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүд.....	29
Дүгнэлт	30
Актив, пассивын бүтэц.....	30
Ашигт ажиллагаа	31
Зохистой харьцааны шалгуур үзүүлэлт.....	31

Хүснэгтийн жагсаалт

Хүснэгт 1 ББСБ-уудын тоо мэдээлэл	5
Хүснэгт 2 Банкны салбартай харьцуулсан ерөнхий үзүүлэлтүүд /тэрбум төгрөгөөр/	5
Хүснэгт 3 ББСБ-уудын эрхэлж буй үйл ажиллагаа	5
Хүснэгт 5 Харилцагчдын мэдээлэл.....	9
Хүснэгт 6 Статистик мэдээлэл /5 жилээр/.....	9
Хүснэгт 7 ББСБ-ын мэдээлэл	10
Хүснэгт 8 Тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаа.....	10
Хүснэгт 9 Улаанбаатар хотын ББСБ-уудын тархалт	10
Хүснэгт 10 Хөдөө орон нутгийн ББСБ-уудын тархалт	10
Хүснэгт 11 Активын үзүүлэлтүүд /сая төгрөгөөр/	11
Хүснэгт 12 Активын интервал /тэрбум төгрөгөөр/	11
Хүснэгт 13 Мөнгөн хөрөнгийн бүтэц /тэрбум төгрөгөөр/.....	12
Хүснэгт 14 Богино хугацаат хөрөнгө оруулалтын бүтэц /сая төгрөгөөр/.....	12
Хүснэгт 15 Факторингийн тооцооны авлагын ангилал /сая төгрөгөөр/.....	13
Хүснэгт 16 ӨБҮХХ болон ӨБХ-ийн бүтэц /сая төгрөгөөр/	13
Хүснэгт 17 Зээлийн бүтэц /тэрбум төгрөгөөр/	13
Хүснэгт 18 Олгосон болон төлөгдсөн зээл салбараар /сая төгрөгөөр/.....	15
Хүснэгт 19 Зээлийн ангилал /тэрбум төгрөгөөр/.....	15
Хүснэгт 20 Зээлийн ангилал	16
Хүснэгт 21 Цахим зээл олгож байгаа ББСБ-ууд	16
Хүснэгт 22 Зөвшөөрөлгүй финтек зээлийн аппликэйшнүүд:	17
Хүснэгт 23 Ногоон зээлийн тайлан /сая төгрөгөөр/.....	18
Хүснэгт 24 Бусад хөрөнгийн бүтэц /сая төгрөгөөр/.....	19
Хүснэгт 25 Эргэлтийн бус хөрөнгийн бүтэц /тэрбум төгрөгөөр/	19
Хүснэгт 26 Пассивын үзүүлэлтүүд /сая төгрөгөөр/	20
Хүснэгт 27 Итгэлцлийн үйлчилгээ /тэрбум төгрөгөөр/.....	21
Хүснэгт 29 Дотоод, гадаадын банк, санхүүгийн байгууллагад төлөх өглөг /тэрбум төгрөгөөр/.....	21
Хүснэгт 30 Бусад эх үүсвэрийн бүтэц /сая төгрөгөөр/.....	22
Хүснэгт 32 ББСБ-аас гаргасан өрийн бичиг /мянган төгрөгөөр/.....	22
Хүснэгт 33 Өрийн бичиг /валютаар/.....	23
Хүснэгт 35 Төслийн зээл санхүүжилт /сая төгрөгөөр/.....	23
Хүснэгт 36 Бусад өр төлбөр /сая төгрөгөөр/.....	23
Хүснэгт 37 Хувьцаат капиталын бүтэц /сая төгрөгөөр/.....	24
Хүснэгт 38 ХНХ-ийн интервал /тэрбум төгрөгөөр/	24
Хүснэгт 39 Бусад өмч, сангуудын бүтэц /сая төгрөгөөр/	25
Хүснэгт 40 Хуримтлагдсан ашиг/алдагдал /тэрбум төгрөгөөр/.....	25
Хүснэгт 42 Орлого, үр дүнгийн тайлан /харьцуулсан, сая төгрөгөөр/.....	26
Хүснэгт 46 Орлого, үр дүнгийн тайлан /сая төгрөгөөр/	27
Хүснэгт 47 2022 оны III улирлын байдлаарх валют арилжааны мэдээ /тэрбум төгрөгөөр/.....	28
Хүснэгт 48 ЗХШҮ /үзүүлэлт бүрээр/.....	29

Зургийн жагсаалт

Зураг 1 Активын үзүүлэлтүүд сүүлийн 5 жилийн байдлаар /тэрбум төгрөгөөр/.....	11
Зураг 2 Мөнгөн хөрөнгийн бүтэц сүүлийн 5 жилийн байдлаар /тэрбум төгрөгөөр/	12
Зураг 4 Зээлийн багцын чанар /тэрбум төгрөгөөр/	14
Зураг 5 Зээлийн багцын чанар /хувиар/.....	14
Зураг 6 Олгосон зээл /хугацааны ангиллаар/.....	15
Зураг 7 Ногоон зээлийн багцын чанар /ногоон таксономийн 8 ангиллаар/.....	18
Зураг 8 Пассивын үзүүлэлтүүд сүүлийн 5 жилийн байдлаар /тэрбум төгрөгөөр/	20
Зураг 9 Итгэлцлийн үйлчилгээний өглөг /тэрбум төгрөгөөр/.....	21

Зураг 10 Бусад эх үүсвэрийн үлдэгдэлтэй ББСБ-ууд /мянган төгрөгөөр/	22
Зураг 11 Өрийн бичгийн үлдэгдэл сүүлийн 5 жилийн байдлаар /тэрбум төгрөгөөр/	22
Зураг 12 Хувьцаат капиталын бүтэц сүүлийн 5 жилийн байдлаар /тэрбум төгрөгөөр/	24
Зураг 13 Ашигт ажиллагааны үзүүлэлт /тэрбум төгрөгөөр/	26

Товчилсон нэрсийн жагсаалт

Товчилсон нэр	Тайлбар
Хороо	Санхүүгийн зохицуулах хороо
ББСБ	Банк бус санхүүгийн байгууллага
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ХК	Хувьцаат компани
СМА	Санхүүгийн мэдээллийн алба
ЗГВА	Гадаад валют арилжаа дагнан эрхэлдэг
УБ	Улаанбаатар хот
ХОН	Хөдөө орон нутаг
ГХО	Гадаадын хөрөнгө оруулалттай
ХНХ	Хувь нийлүүлсэн хөрөнгө
БХХО	Богино хугацаат хөрөнгө оруулалт
ӨБҮХХ	Өмчлөх бусад үл хөдлөх хөрөнгө
ӨБХ	Өмчлөх бусад хөрөнгө
ЗЖДХ	Зээлийн жигнэсэн дундаж хүү
ЗХШҮ	Зохистой харьцааны шалгуур үзүүлэлт

Банк бус санхүүгийн байгууллагын салбарын ерөнхий төлөв байдал

2022 оны III улирлын байдлаар Санхүүгийн зохицуулах хорооноос банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан 522 ББСБ байгаа нь өмнөх оны мөн үеэс 9 ББСБ буюу 1.7 хувиар буурсан үзүүлэлт юм. Эдгээр ББСБ-уудын 91 нь хөдөө орон нутагт үйл ажиллагаа эрхэлж байгаа бол гадаадын хөрөнгө оруулалттай 26 ББСБ, олон нийтэд хувьцаагаа санал болгосон 5 ББСБ байна.

Хүснэгт 1 ББСБ-уудын тоо мэдээлэл

	2018-III	2019-III	2020-III	2021-III	2022-III
Шинээр олгосон	13	9	12	9	14
Хүчингүй	7	9	8	10	26
Түдгэлзүүлсэн	17	10	25	20	57
Сэргээсэн	7	8	4	6	19
Нийт ББСБ	540	539	533	531	522
Үүнээс: ХОН	76	74	77	80	91
Үүнээс: ГХО	28	28	29	29	26
Салбар	206	240	285	313	419
Төлөөлөгч	5	7	9	8	7

2022 оны III улиралд 14 хуулийн этгээдэд шинээр банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгосон бол 26 ББСБ-ын тусгай зөвшөөрлийг хүчингүй болгож, 57 ББСБ-ын үйл ажиллагааг түдгэлзүүлж, 19 ББСБ-ын үйл ажиллагааг сэргээсэн байна.

Санхүүгийн үйлчилгээнд техник технологийг ашиглаж, шинэ төрлийн үйлчилгээ бий болгохоос гадна уламжлалт зээлийн үйлчилгээг хялбар, түргэн, шуурхай болгож буй онлайн зээлийн үйлчилгээг 2022 оны III улирлын байдлаар 36 ББСБ үзүүлж байна.

Хүснэгт 2 Банкны салбартай харьцуулсан ерөнхий үзүүлэлтүүд /тэрбум төгрөгөөр/

Үзүүлэлтүүд	2021-III	2022-III	Өсөлтийн хувь
Нийт хөрөнгө	2,460.1	3,400.8	38.2%
Банкны салбартай харьцуулахад хувиар	6.2%	8.2%	2.0%
Нийт өөрийн хөрөнгө	1,682.1	2,124.7	26.3%
Банкны салбартай харьцуулахад хувиар	52.1%	53.4%	1.3%
Нийт хувь нийлүүлсэн хөрөнгө	1,078.4	1,275.5	18.3%
Банкны салбартай харьцуулахад хувиар	100.5%	80.5%	-20.0%
Нийт зээл	1,765.9	2,666.1	51.0%
Банкны салбартай харьцуулахад хувиар	8.6%	11.4%	2.8%
Нийт орлого	354.2	624.8	76.4%
Нийт зарлага	206.4	389.8	88.8%
Цэвэр ашиг	147.8	235.0	59.0%

ББСБ-уудын нийт активын хэмжээ өмнөх оны мөн үеэс 38.2 хувиар өсөж, банкны салбарын 8.2%-тай тэнцэж байна. Харин хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ банкны салбарын 80.5%-тай тэнцэж байгаа нь өмнөх оны мөн үеүдтэй харьцуулахад 20.0 пунктээр буурсан дүн юм. Энэ нь ББСБ-уудын бусдаас татан төвлөрүүлж буй эх үүсвэрийн хэмжээ нэмэгдэж байгааг харуулж байна.

2022 оны III улирлын байдлаар банк бус санхүүгийн байгууллагын салбарын нийт хөрөнгө өмнөх оны мөн үеэс 38.2 хувиар буюу 940.7 тэрбум төгрөгөөр өсөж 3.4 их наяд төгрөгт хүрсэн байна. Активын өсөлтийн 93.0 хувийг цэвэр зээлийн өсөлт, пассивын өсөлтийн 53.0 хувийг өр төлбөрийн өсөлт, 47.0 хувийг өөрийн хөрөнгийн өсөлт бүрдүүлж байна.

ББСБ-уудын ашигт ажиллагаа огцом өсөлт үзүүлж өмнөх оны мөн үетэй харьцуулахад нийт орлогын хэмжээ 76.4 хувиар буюу 270.6 тэрбум төгрөгөөр, нийт зардлын хэмжээ 88.8 хувиар буюу 183.4 тэрбум төгрөгөөр, цэвэр ашгийн хэмжээ 59.0 хувиар буюу 87.3 тэрбум төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 3 ББСБ-уудын эрхэлж буй үйл ажиллагаа

№	Үйл ажиллагааны нэр төрөл	ББСБ-ын тоо		Өөрчлөлт	
		2021-III	2022-III	тоо	хувь
	Нийт ББСБ-ын тоо	531	522	-9	-1.7%
1	Зээл	493	484	-9	-1.8%
	<i>Зээлийн үйл ажиллагаа дагнан эрхэлдэг</i>	<i>324</i>	<i>316</i>	<i>-8</i>	<i>-2.5%</i>
2	Факторинг	38	43	5	13.2%
3	Төлбөрийн баталгаа гаргах	22	28	6	27.3%
4	Төлбөр тооцооны хэрэгсэл гаргах	5	5	-	0.0%
5	Пахим төлбөр тооцоо мөнгөн гуйвуулга	35	37	2	5.7%
6	Гадаад валютын арилжаа	147	140	-7	-4.8%
	<i>Гадаад валютын арилжаа дагнан эрхэлдэг</i>	<i>38</i>	<i>38</i>	<i>-</i>	<i>-</i>
7	Итгэлцэл	46	61	15	32.6%
	Богино хугацаат санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулалт хийх	18	22	4	22.2%
	Хөрөнгө оруулалт санхүүгийн чиглэлээр зөвлөгөө мэдээлэл өгөх	39	40	1	2.6%
10	Үл хөдлөх эд хөрөнгө барьцаалахтай холбоотой санхүүгийн зуучлалын үйл ажиллагаа	-	1	1	-

Үйл ажиллагааны төрлөөр авч үзвэл 522 ББСБ 10 төрлийн үйл ажиллагааг тусгай

зөвшөөрлийн хүрээнд эрхэлж байна. Нийт ББСБ-уудын 92.7% нь буюу 484 ББСБ зээлийн үйл ажиллагаа эрхэлж байгаа ба үүнээс 60.5% нь буюу 316 ББСБ дагнан эрхэлж байна. Харин гадаад валютын арилжааны үйл ажиллагаа эрхэлж байгаа 140 ББСБ байгаа нь нийт ББСБ-уудын 26.8 хувийг, гадаад валютын арилжааны үйл ажиллагаа дагнан эрхэлж байгаа 38 ББСБ нийт ББСБ-уудын 7.3 хувийг бүрдүүлж байна.

Зээл болон гадаад валют арилжааны үйл ажиллагаа эрхэлдэг ББСБ-ын тоо өмнөх оны мөн үеэс харгалзан 1.8 хувь, 4.8 хувиар буурч, бусад төрлийн үйл ажиллагааны тоо нэмэгдэж байгаа нь ББСБ-ууд үйл ажиллагааны цар хүрээгээ тэлж байгааг харуулж байна. Харин өмнөх оны мөн үеэс нэмэгдсэн үйл ажиллагааны төрлийг авч үзвэл итгэлцлийн үйлчилгээ 32.6 хувиар, төлбөрийн баталгаа гаргах үйлчилгээ 27.3 хувиар, богино хугацаат санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулалт хийх үйлчилгээ 22.2 хувиар, факторинг 13.2 хувиар тус тус өссөн байна.

Тайлант улиралд Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.11-д заасан үл хөдлөх эд хөрөнгө барьцаалахтай холбоотой санхүүгийн зуучлалын үйл ажиллагааг анх удаа [Санхүүгийн зохицуулах хорооны 2022 оны 5 дугаар сарын 11-ний өдрийн 223 дугаар тогтоолоор](#) олгосон байна.

Үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны тухай хууль 2009 оны 7 дугаар сарын 09-ний өдөр батлагдсан бөгөөд үүнтэй холбоотой үйл ажиллагаа эрхлэх этгээдэд Санхүүгийн зохицуулах хорооноос тусгай зөвшөөрөл олгохоор Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулж энэхүү тусгай зөвшөөрлийг нэмсэн бөгөөд 2022 оны эхний хагас жил хүртэл тусгай зөвшөөрөл авсан ББСБ байгаагүй юм.

2022 оны III улирлын тайлан мэдээний ирц 96.2% байна. Тайлан мэдээг ирүүлбэл зохих 522 ББСБ-аас 502 ББСБ улирлын тайлан мэдээ ирүүлснийг холбогдох журмын дагуу хянаж, тайлангийн нэгтгэлд хамруулсан бөгөөд нэр бүхий 20

ББСБ өмнөх үеийн тайлан тэнцлээр нэгтгэлд хамрагдлаа.

Өмнөх улирлын байдлаар нэгтгэлд хамрагдсан 20 ББСБ-аас 14 ББСБ-ын үйл ажиллагааг түдгэлзүүлэх арга хэмжээг Хяналт шалгалт зохицуулалтын газраас авч хэрэгжүүлсэн байна.

Хууль, тогтоомж болон журмын өөрчлөлт, хэрэгжилт

Банк бус санхүүгийн байгууллагын салбарт мөрдөгдөх дүрэм, журмуудыг хууль тогтоомжид нийцүүлэн шинээр боловсруулах, шинэчлэх, нэмэлт өөрчлөлт оруулах арга хэмжээний хүрээнд дараах дүрэм журмуудыг шинэчлэн Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд бүртгүүллээ.

- Санхүүгийн зохицуулах хорооны 2022 оны 4 дүгээр сарын 06-ны өдрийн 160 дугаар тогтоолоор “[Банк бус санхүүгийн зээлийн үйл ажиллагааны журам](#)”-ыг баталж, Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд 2022 оны 4 дүгээр 28-ны өдрийн 5807 дугаарт бүртгэн авсан байна.

- Санхүүгийн зохицуулах хорооны 2019 оны 441 дүгээр тогтоол /*Банк бус санхүүгийн байгууллагын хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээ, үе шаттай нэмэгдүүлэх хуваарийг шинэчлэн батлах тухай*/-ын 2021 оны хуваарийг цар тахал үүссэн онцгой нөхцөл байдлыг харгалзан 1 жилээр хойшлуулж 2022 оны 02 дугаар сарын 10-ны өдрийг хүртэл сунгасан. Энэхүү тогтоолоор Улаанбаатар хотод үйл ажиллагаа эрхэлж байгаа ББСБ-ууд хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг 1.9 тэрбум төгрөгт, Орхон аймаг Баян-Өндөр сум, Дархан-Уул аймгийн Дархан сумд үйл ажиллагаа эрхэлж байгаа ББСБ-ууд 475 сая төгрөгт, гадаад валют арилжаа дагнан эрхэлж буй ББСБ-ууд Улаанбаатар хотод 300.0 сая төгрөг, бусад аймаг сумдад 200 сая төгрөгт хүргэх шаардлага үүссэн билээ. Гэвч ББСБ-уудаас материал хүлээн авах хугацааг хойшлуулах хүсэлтүүд ирснийг харгалзан Санхүүгийн зохицуулах хорооны 2022 оны 02 дугаар сарын 23-ны өдрийн 01 дүгээр хуралдааны тэмдэглэлээр материал хүлээн авах хугацааг 2022 оны 3 дугаар сарын 31-ний өдрийг хүртэл хугацаанд сунгасан байна.

- Санхүүгийн зохицуулах хорооны 2022 оны 5 дугаар сарын 25-ны өдрийн 287 дугаар тогтоолоор “Банк бус санхүүгийн байгууллагын үйл

ажиллагаанд эрсдэлд суурилсан хяналт шалгалт хийх журам”-д нэмэлт өөрчлөлт оруулж, Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд 2022 оны 6 дугаар сарын 08-ны өдөр бүртгэн авсан байна.

“Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай” хуулийн 15 дугаар зүйлийн 15.4 дэх заалтын хэрэгжилт

2022 оны III улирлын байдлаар Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.4-т заасны дагуу 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг хөндлөнгийн аудитаар баталгаажуулах үүргийг 88.8 хувь буюу 451 ББСБ, нийтэд мэдээлэх үүргийг 83.1 хувь нь 422 ББСБ хэрэгжүүлсэн байна.

“Зээлийн мэдээллийн тухай” хуулийн хэрэгжилт

Зээлийн мэдээллийн тухай хуульд заасны дагуу зээлийн үйл ажиллагаа эрхлэх байгууллагууд Монголбанкны зээлийн мэдээллийн сантай хамтран ажиллах гэрээг байгуулан зээлдэгчийн талаарх мэдээлэл, лавлагааг зээлийн үйл ажиллагаандаа авч ашиглах үүрэгтэй. Монголбанкны Ерөнхийлөгчийн 2020 оны 3 дугаар сарын 03-ны өдрийн А-57 дугаар тушаалаар “Монголбанкны зээлийн мэдээллийн сангийн журам”-ыг шинэчлэн баталсантай холбоотойгоор Монголбанкнаас мэдээлэл нийлүүлэгч байгууллагуудтай хамтран ажиллах гэрээг нэгдсэн журмаар шинэчлэн байгуулах ажлыг зохион байгуулж, тайлант улиралд зээлийн үйл ажиллагаа эрхэлж буй 489 ББСБ-ын 86.7% буюу 424 ББСБ гэрээгээ шинэчлэн байгуулсан байна.

“Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай” хуулийн хэрэгжилт

Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1-д “Энэ хуулийн 4.1-д заасан этгээд 20 сая төгрөг, түүнээс дээш үнийн дүнтэй бэлэн мөнгөний болон гадаад төлбөр тооцооны гүйлгээний тухай мэдээллийг гүйлгээ хийгдсэнээс хойш ажлын таван өдрийн дотор батлагдсан

маягт, журмын дагуу Санхүүгийн мэдээллийн албанд мэдээлэх үүрэгтэй.” гэж заасны дагуу нэр бүхий 115 ББСБ, 9,138 удаагийн тохиолдлоор, 1.5 их наяд төгрөгийг, 7.2-т “Хөрөнгө, гүйлгээ, гүйлгээ хийх оролдлогыг мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй, эсхүл гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлоготой холбоотой гэж сэжиглэсэн, эсхүл мэдсэн бол энэ хуулийн 4.1-д заасан этгээд энэ тухай 24 цагийн дотор сэжигтэй гүйлгээний тухай батлагдсан маягт, журмын дагуу Санхүүгийн мэдээллийн албанд мэдээлнэ.” гэж заасны дагуу нэр бүхий 8 ББСБ, 34 удаагийн тохиолдлоор,

1.6 тэрбум төгрөгийг Монголбанкны СМА-нд тус тус мэдээлж, хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ хэрэгжүүлсэн байна.

“Зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээг тогтоох, төвлөрүүлэх журам”-ын хэрэгжилт

2022 оны III улирлын байдлаар нийт 511 ББСБ-аас 1,257.6 сая төгрөгийн зохицуулалт үйлчилгээний хөлс төлөхөөс 93.1% буюу 482 ББСБ 1,170.9 сая төгрөгийн зохицуулалтын үйлчилгээний хөлсийг Хорооны холбогдох дансанд төвлөрүүлсэн байна.

Статистик үзүүлэлтүүд

2022 оны III улирлын байдлаар давхардсан тоогоор 23,143 хувьцаа эзэмшигчдийн 522 ББСБ, 419 салбар нэгж, 8 төлөөлөгчийн газар, 4,478 ажилтантайгаар Монгол улсын 21 аймаг, 8 дүүрэгт давхардсан тоогоор 4.9 сая харилцагч, 1.6 сая зээлдэгчид хүрч үйлчилж байна.

Харилцагчид, зээлдэгчид

Нийт харилцагчдын тоо өмнөх оны мөн үеэс 8.1 хувиар өсөж давхардсан тоогоор 4,897,575-д, зээлдэгчдийн тоо өмнөх оны мөн үеэс 5.2 хувиар өсөж 1,644,423-д хүрлээ.

Хүснэгт 4 Харилцагчдын мэдээлэл

Статистик мэдээлэл	Дүн	Итгэлцэл	Уламжлалт	Финтек	ЗГВ	УБ	ХОН	ХК	ГХО
Нийт харилцагчдын тоо	4,897,575	3,845,737	374,364	4,523,211	35,091	4,879,842	17,733	1,201,658	136,418
Үүнээс: Эмэгтэй	2,857,346	1,963,277	198,036	2,659,310	20,218	2,846,372	10,974	608,853	71,903
Эрэгтэй	2,036,219	1,881,564	172,892	1,863,327	12,982	2,029,510	6,709	592,325	64,225
Хуулийн этгээд	4,010	896	3,436	574	1,891	3,960	50	480	290
Итгэмжлэгчдийн тоо	5,756	5,579	3,189	2,567	-	5,747	9	1,118	289
Өрийн бичиг авсан харилцагчдын тоо	1,872	1,810	240	1,632	-	1,854	18	907	137
Зээлдэгчдийн тоо	1,644,423	644,657	325,855	1,318,568	-	1,626,718	17,705	209,842	136,369
Хэвийн	1,507,602	544,447	284,757	1,222,845	-	1,492,707	14,895	172,584	114,069
Хугацаа хэтэрсэн	45,080	30,584	11,677	33,403	-	44,250	830	9,237	5,294
Чанаргүй:	91,741	69,626	29,421	62,320	-	89,761	1,980	28,021	17,006
-Хэвийн бус	33,852	24,150	9,738	24,114	-	33,303	549	8,704	5,880
-Эргэлзээтэй	33,555	26,323	9,676	23,879	-	32,899	656	10,206	6,097
-Муу	24,334	19,153	10,007	14,327	-	23,559	775	9,111	5,029
Зээлдэгчдийн насжилт	1,642,794	644,101	324,502	1,318,292	-	1,625,139	17,655	209,637	136,087
18-35 насны	529,848	378,405	178,372	351,476	-	523,337	6,511	135,321	90,126
36-45 насны	961,640	163,666	87,559	874,081	-	955,782	5,858	48,678	29,285
46-55 насны	118,100	75,567	44,997	73,103	-	114,285	3,815	21,227	13,240
55-аас дээш	33,206	26,463	13,574	19,632	-	31,735	1,471	4,411	3,436
Зээлдэгчдийн боловсрол	1,642,794	644,101	324,502	1,318,292	-	1,625,139	17,655	209,637	136,087
-Дээд	1,157,313	375,100	189,076	968,237	-	1,147,154	10,159	128,421	86,606
-Тусгай дунд	188,655	54,094	39,848	148,807	-	185,932	2,723	24,292	21,167
-Бүрэн дунд	214,976	146,946	73,499	141,477	-	211,467	3,509	46,108	22,133
-Дунд	55,508	46,049	10,908	44,600	-	54,445	1,063	8,991	5,731
-Бага	26,342	21,912	11,171	15,171	-	26,141	201	1,825	450

/Финтек ББСБ-ууд уламжлалт зээл давхар олгодог болно/

Нийт харилцагчдын 92.4% буюу 4,523,211 нь, зээлдэгчдийн 80.2% буюу 1,318,568 нь санхүүгийн үйлчилгээнд техник технологийг ашиглаж /финтек/, онлайн зээлийн үйлчилгээ нэвтрүүлж буй ББСБ-уудын харилцагч, зээлдэгч байгаа бол нийт харилцагчдын 7.6% буюу 374,364 нь, зээлдэгчдийн 19.8% буюу 325,855 нь уламжлалт ББСБ-ын харилцагч, зээлдэгч байна. Гадаад валют арилжааны үйлчилгээ дагнан эрхэлдэг ББСБ-уудын харилцагчид 35,091 буюу нийт харилцагчдын 0.7 хувийг бүрдүүлж байна.

Хүснэгт 5 Статистик мэдээлэл /5 жилээр/

Үзүүлэлтүүд	2018-III	2019-III	2020-III	2021-III	2022-III	Өөрчлөлт	
						Дүнгээр	Хувиар
Хувьцаа эзэмшигчдийн тоо	4,766	7,672	8,669	21,666	23,143	1,477	6.8%
Ажилчдын тоо	2,652	3,003	3,417	3,820	4,478	658	17.2%
Харилцагчдын тоо	1,510,982	1,575,389	2,639,297	4,530,126	4,897,575	367,449	8.1%
Зээлдэгчдийн тоо	217,623	383,670	551,977	1,562,757	1,644,423	81,666	5.2%
Зээлийн жигнэсэн дундаж хүү	3.3%	3.1%	2.9%	2.6%	3.1%	+0.5 пункт	

Хувьцаа эзэмшигчид болон ажилчид

Нийт хувьцаа эзэмшигчдийн тоо өмнөх оны мөн үеэс 6.8 хувиар буюу 1,477-оор өсөж 23,143-д хүрчээ. Нийт хувьцаа эзэмшигчдийн 95.6 хувь буюу 22,135 нь олон нийтэд хувьцаагаа санал болгосон ББСБ-уудын хувьцаа эзэмшигч байгаа бол 1,008 буюу 4.4% нь хязгаарлагдмал хариуцлагатай компанийн хувьцаа эзэмшигчид байна. Мөн хувьцаа эзэмшигчдийн 2,443 буюу 10.6% нь гадаадын хөрөнгө оруулалттай ББСБ-уудын хувьцаа эзэмшигчид байгаа бол 209 буюу 0.9% нь хөдөө орон нутгийн ББСБ-уудын хувьцаа эзэмшигчид байна.

Хүснэгт 6 ББСБ-ын мэдээлэл

Статистик мэдээлэл	НИЙТ	Итгэлцэл	Уламжлалт	Финтек	ЗГВА	УБ	ХОН	ХК	ГХО
Хувьцаа эзэмшигчдийн тоо	23,143	22,291	3,329	19,814	59	22,934	209	22,135	2,443
Нийт ажилтнуудын тоо	4,478	2,203	2,698	1,780	95	4,231	247	389	431
Үүнээс: Эмэгтэй ажилтны тоо	2,648	1,249	1,626	1,022	52	2,477	171	255	255
Эрэгтэй ажилтны тоо	1,830	954	1,072	758	43	1,754	76	134	176

Хөдөө орон нутгийн 91 ББСБ 6 төрлийн тусгай зөвшөөрлийн хүрээнд үйл ажиллагаа эрхэлж байна.

Хүснэгт 7 Тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаа

	НИЙТ	Итгэлцэл	Уламжлалт	Финтек	ЗГВА	УБ	ХОН	ХК	ХХК	ГХО
ТЗ-тэй ББСБ-ын тоо	522	61	486	36	38	431	91	5	517	26
1 Зээл	484	61	448	36	-	394	90	5	479	26
2 Факторингийн үйлчилгээ	43	18	31	12	-	43	-	3	40	2
3 Төлбөрийн баталгаа гаргах	28	14	22	6	-	27	1	2	26	5
4 Төлбөр тооцооны хэрэгсэл гаргах	5	2	1	4	-	5	-	1	4	-
5 Цахим төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулгын үйлчилгээ	37	17	25	12	-	37	-	3	34	-
6 Гадаад валютын арилжаа	140	29	127	13	38	130	10	4	136	8
7 Итгэлцлийн үйлчилгээ	61	61	45	16	-	60	1	5	56	6
8 Богино хугацаат санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулалт хийх	22	16	15	7	-	21	1	2	20	4
9 Хөрөнгө оруулалт, санхүүгийн чиглэлээр зөвлөгөө, мэдээлэл өгөх	40	21	30	10	-	38	2	4	36	5
10 Үл хөдлөх эд хөрөнгө барьцаалахтай холбоотой санхүүгийн зуучлалын үйл ажиллагаа	1	1	1	-	-	1	-	-	1	1

Тархалт

Улаанбаатар хотод нийт ББСБ-уудын 82.6% буюу 431 ББСБ, салбаруудын 62.8% буюу 263 салбар байршиж байна. Харин хөдөө орон нутагт нийт ББСБ-ын 17.4% буюу 91 ББСБ, салбаруудын 37.2% буюу 156 салбар бүртгэлтэй үйл ажиллагаа эрхэлж байна.

2022 оны III улирлын байдлаар 91 ББСБ-ын 419 салбар бүртгэлтэй байгаа ба эдгээрийн 66.3 хувийг 15 ББСБ-ын 278 салбар бүрдүүлж байна.

Хүснэгт 8 Улаанбаатар хотын ББСБ-уудын тархалт

Дүүрэг	Үндсэн 431	Салбар 263	Нийт 694	Хувь 100.0%
Сүхбаатар дүүрэг	146	39	185	26.7%
Чингэлтэй дүүрэг	117	38	155	22.3%
Баянгол дүүрэг	73	39	112	16.1%
Баянзүрх дүүрэг	48	64	112	16.1%
Хан-Уул дүүрэг	37	32	69	9.9%
Сонгинохайрхан дүүрэг	9	44	53	7.6%
Багануур дүүрэг	1	4	5	0.7%
Налайх дүүрэг	-	3	3	0.4%

ББСБ-ууд хөдөө орон нутгаас Орхон, Төв, Өвөрхангай аймгуудад, Улаанбаатар хотоос Сүхбаатар, Чингэлтэй дүүргүүдэд хамгийн ихээр төвлөрч үйлчилгээгээ хүргэж байна.

Хүснэгт 9 Хөдөө орон нутгийн ББСБ-уудын тархалт

Аймаг	Үндсэн 91	Салбар 156	Нийт 247	Хувь 100%
Архангай аймаг	2	6	8	3.2%
Баян-Өлгий аймаг	4	4	8	3.2%
Баянхонгор аймаг	4	7	11	4.5%
Булган аймаг	2	1	3	1.2%
Говь-Алтай аймаг	1	1	2	0.8%
Говьсүмбэр аймаг	2	3	5	2.0%
Дархан-Уул аймаг	8	13	21	8.5%
Дорноговь аймаг	1	8	9	3.6%
Дорнод аймаг	5	13	18	7.3%
Дундговь аймаг	-	4	4	1.6%
Завхан аймаг	2	4	6	2.4%
Орхон аймаг	9	16	25	10.1%
Өвөрхангай аймаг	10	12	22	8.9%
Өмнөговь аймаг	2	14	16	6.5%
Сүхбаатар аймаг	5	6	11	4.5%
Сэлэнгэ аймаг	5	11	16	6.5%
Төв аймаг	18	4	22	8.9%
Увс аймаг	4	8	12	4.9%
Ховд аймаг	1	5	6	2.4%
Хөвсгөл аймаг	3	8	11	4.5%
Хэнтий аймаг	3	8	11	4.5%

Активын бүтэц, бүрэлдэхүүн, өөрчлөлт


2022 оны III улирлын байдлаар банк бус санхүүгийн салбарын нийт хөрөнгө 3.4 их наяд төгрөгт хүрсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 38.2 хувиар буюу 940.7 тэрбум төгрөгөөр өсжээ. Активын өсөлтийн 93.0 хувийг цэвэр зээлийн өсөлт бүрдүүлж байна. Активын үзүүлэлтүүдийг өмнөх оны мөн үетэй харьцуулж үзвэл:

Хүснэгт 10 Активын үзүүлэлтүүд /сая төгрөгөөр/

Активын үзүүлэлтүүд	2021-III дүн	Нийт дүнд эзлэх хувь	2022-III дүн	Нийт дүнд эзлэх хувь	Өөрчлөлт	
					дүн	хувь
Эргэлтийн хөрөнгө	2,369,244.2	96.3%	3,294,186.2	96.9%	924,942.0	39.0%
Мөнгөн хөрөнгө	435,923.4	17.7%	401,993.4	11.8%	-33,930.0	-7.8%
Богино хугацаат хөрөнгө оруулалт (цэврээр)	19,065.9	0.8%	15,957.6	0.5%	-3,108.4	-16.3%
Зээл (цэврээр)	1,648,960.1	67.0%	2,524,028.7	74.2%	875,068.6	53.1%
Нийт зээл	1,765,925.5	71.8%	2,666,130.1	78.4%	900,204.6	51.0%
(Зээлийн эрсдэлийн сан)	116,965.3	4.8%	142,101.3	4.2%	25,136.0	21.5%
Факторингийн тооцооны авлага (цэврээр)	10,714.3	0.4%	10,355.5	0.3%	-358.8	-3.3%
Өмчлөх бусад үл хөдлөх болон өмчлөх бусад хөрөнгө (цэврээр)	12,414.1	0.5%	19,666.2	0.6%	7,252.2	58.4%
Бусад хөрөнгө	242,166.4	9.8%	322,144.1	9.5%	79,977.7	33.0%
Санхүүгийн үүсмэл хэрэгсэл (дериватив)-ийн авлага	0.0	-	40.6	0.0%	40.6	-
Эргэлтийн бус хөрөнгө	90,866.2	3.7%	106,607.0	3.1%	15,740.8	17.3%
Үндсэн (биет) ба биет бус хөрөнгө	115,618.7	4.7%	138,840.7	4.1%	23,222.0	20.1%
(Хуримтлагдсан элэгдэл)	-24,752.5	-1.0%	-32,233.7	-0.9%	-7,481.2	30.2%
Нийт хөрөнгийн дүн	2,460,110.4	100.0%	3,400,793.2	100.0%	940,682.8	38.2%

Сүүлийн 5 жилийн активын үзүүлэлтийг харвал салбарын нийт актив 2018 оны мөн үед 1.2 их наяд төгрөг байсан бол 2022 оны III улирлын байдлаар 2.8 дахин өсөж 3.4 их наяд төгрөгт хүрчээ. Энэ нь цэвэр зээлийн үлдэгдэл 3.4 дахин өссөнтэй холбоотой.

Зураг 1 Активын үзүүлэлтүүд сүүлийн 5 жилийн байдлаар /тэрбум төгрөгөөр/



Салбарын нийт хөрөнгийн 89.4% нь 2.5 тэрбум төгрөг ба түүнээс дээш хөрөнгөтэй 256 ББСБ, 7.4% нь 1.9-2.5 тэрбум төгрөг хүртэлх активтай 117 ББСБ байгаа бол нийт салбарын хөрөнгийн 3.2 хувийг 1.9 тэрбум төгрөг хүртэлх активтай 149 ББСБ-ын хөрөнгө бүрдүүлж байна.

Хүснэгт 11 Активын интервал /тэрбум төгрөгөөр/

Интервал	Нийт		Эзлэх хувь		Дархан, Эрдэнэт		Бусад аймаг, сумд		ЗГВА	
	Актив	ББСБ тоо	Актив	ББСБ тоо	Актив	ББСБ тоо	Актив	ББСБ тоо	Актив	ББСБ тоо
5.0 тэрбумаас дээш	2,552.0	107	75.0%	20.5%	7.2	1	14.8	2	5.3	1
2.5-5.0 тэрбум	487.9	149	14.3%	28.5%	6.4	2	9.2	3	2.5	1
1.9-2.5 тэрбум	253.2	117	7.4%	22.4%	8.8	4	2.2	1	2.0	1
1.4-1.9 тэрбум	55.7	34	1.6%	6.5%	3.4	2	14.2	9	-	-
0.6-1.4 тэрбум	24.9	25	0.7%	4.8%	2.4	3	11.1	12	3.7	4
0.6 тэрбум хүртэлх	27.2	90	0.8%	17.2%	0.8	2	15.4	57	10.9	31
НИЙТ	3,400.8	522	100.0%	100.0%	29.0	14	66.9	84	24.4	38

Салбарын хамгийн өндөр активтай 20 ББСБ-ын актив 1.7 их наяд төгрөг байгаа нь нийт активын 50.1 хувийг, нийт зээлийн үлдэгдэл 1.4 их наяд төгрөг байгаа нь нийт зээлийн үлдэгдлийн 52.7 хувийг бүрдүүлж байна.

Мөнгөн хөрөнгө


Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл өмнөх оны мөн үеэс 33.9 тэрбум төгрөгөөр буюу 7.8 хувиар буурч 402.0 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй гарсан байна. Бүтцээр нь авч үзвэл 29.6% нь бэлэн мөнгө хэлбэрээр, 41.8% нь банк, санхүүгийн байгууллагын харилцах дансанд 28.6% нь банк, санхүүгийн байгууллагын хадгаламжийн дансанд байршиж байна.

Хүснэгт 12 Мөнгөн хөрөнгийн бүтэц /тэрбум төгрөгөөр/

	Нийт	Итгэлцэл	Уламжлалт	Финтек	ЗГВА	УБ	ХОН	ХК	ГХО
МӨНГӨН ХӨРӨНГӨ	402.0	141.5	292.8	109.2	23.8	387.0	15.0	39.7	47.3
Бэлэн мөнгө	119.2	4.6	116.3	2.8	17.7	111.8	7.3	0.0	3.5
Харилцах	168.0	70.8	109.6	58.4	5.6	161.1	6.9	20.7	15.7
Хадгаламж	114.8	66.2	66.9	48.0	0.5	114.0	0.8	19.0	28.2

ББСБ-уудын мөнгөн хөрөнгийн бүтцийг авч үзвэл уламжлалт үйл ажиллагаа явуулж байгаа ББСБ-уудын мөнгөн хөрөнгийн 39.7%, финтек ББСБ-уудын мөнгөн хөрөнгийн 2.6%, эрхэлж буй үйл ажиллагааны онцлогоос хамаарч валют арилжаа дагнан эрхэлж буй ББСБ-уудын 74.4% нь бэлэн мөнгө хэлбэрээр тус тус байршиж байна.

Зураг 2 Мөнгөн хөрөнгийн бүтэц сүүлийн 5 жилийн байдлаар /тэрбум төгрөгөөр/



Богино хугацаат хөрөнгө оруулалт

Богино хугацаат хөрөнгө оруулалт өмнөх оны мөн үеэс 16.3% буюу 3.1 тэрбум төгрөгөөр буурч, 2022 оны III улирлын байдлаар 25 ББСБ 16.0 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтын үлдэгдэлтэй гарсан байна. Богино хугацаат хөрөнгө оруулалтын 53.6% буюу 8.5 тэрбум төгрөгийг хөрөнгө оруулалтын үнэт цаас, 47.0% буюу 7.5 тэрбум төгрөгийг арилжааны үнэт цаас бүрдүүлж байна. Төрлөөр авч үзвэл 73.1% буюу 11.7 тэрбум төгрөг нь хувьцаа, 26.3% буюу 4.2 тэрбум төгрөг нь өрийн бичгээр, 1.2% буюу 186.1 сая төгрөг нь бусад үнэт цаасаар хөрөнгө оруулалт байна.

Хүснэгт 13 Богино хугацаат хөрөнгө оруулалтын бүтэц /сая төгрөгөөр/

	Дүн	Итгэлцэл	Уламжлалт	Финтек	ЗГВ	УБ	ХОН	ХК	ГХО
БХХО (ЦЭВРЭЭР)	15,957.6	14,524.7	8,793.6	7,164.0	1.0	15,182.3	775.3	9,300.4	6,279.4
Хувьцаа	11,669.7	10,246.8	8,282.6	3,387.1	1.0	10,894.4	775.3	8,114.9	5,878.4
Өрийн бичиг	4,201.0	4,201.0	501.0	3,700.0	-	4,201.0	-	1,009.4	401.0
Бусад	186.1	176.1	10.0	176.1	-	186.1	-	176.1	-
Хөрөнгө оруулалтын үнэт цаас	8,553.4	7,917.4	6,514.4	2,039.0	-	8,518.8	34.6	6,523.5	5,878.4
Арилжааны үнэт цаас	7,503.3	6,706.5	2,279.2	5,224.2	1.0	6,762.7	740.7	2,776.9	401.0

Тайлант улиралд богино хугацаат санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулалт хийх тусгай зөвшөөрөлтэй 22 ББСБ бүртгэлтэй байгаа хэдий ч 25 ББСБ санхүүгийн тайлангаар богино хугацаат хөрөнгө оруулалтын үлдэгдэлтэй гарсан ба эдгээрийн 12 ББСБ нь тусгай зөвшөөрөлтэй байна.

Засгийн газрын бондыг эрсдэлгүй гэж үзэн СЗХ-оос тухайн төрлийн бондыг тусгай зөвшөөрөлгүйгээр авах боломжтой гэж үзсэн хэдий ч санхүүгийн тайлангийн Засгийн газрын үнэт цаас хэсэгт бүртгэсэн дүн байхгүй байна. Иймээс 13 ББСБ тусгай зөвшөөрөлгүй

энэхүү үйл ажиллагааг эрхэлсэн байгаа тул холбогдох арга хэмжээг авч ажиллах шаардлагатай байна.

Факторингийн тооцооны авлага

Факторингийн тооцооны авлага өмнөх оны мөн үеэс 2.9% буюу 318.3 тэрбум төгрөгөөр буурч, 13 ББСБ 10.5 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй гарчээ. Факторингийн үйлчилгээний тусгай зөвшөөрөлтэй ББСБ-уудын тоо өмнөх оны мөн үетэй харьцуулахад нэмэгдсэн хэдий ч 2022 оны III улирлын байдлаар 5 ББСБ 509.5 сая төгрөгийн анхаарал хандуулах болон чанаргүй факторингийн үлдэгдэлд 155.6 сая төгрөгийн эрсдэлийн сан байгуулж, 10.4 тэрбум төгрөгийн цэвэр үлдэгдэлтэй гарчээ. Факторингийн тусгай зөвшөөрөлтэй 43 ББСБ-уудын 29 ББСБ нь тусгай зөвшөөрөл олгосноос хойш үйл ажиллагаа эрхлэхгүй байгаа нь тул журамд заасны дагуу тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох шаардлагатай гэж үзэж байна.

Хүснэгт 14 Факторингийн тооцооны авлагын ангилал /сая төгрөгөөр/

Нийт факторингийн тооцооны авлага	2021-III		2022-III		Өөрчлөлт	
	Нийт дүн	Эзлэх хувь	Нийт дүн	Эзлэх хувь	Дүн	Хувь
	10,829.4	100.0%	10,511.1	100.0%		
Хэвийн	10,190.0	94.1%	10,001.6	95.2%	(188.4)	-1.8%
Анхаарал хандуулах	319.2	2.9%	167.9	1.6%	(151.3)	-47.4%
Чанаргүй	320.2	3.0%	341.6	3.3%	21.5	6.7%
Хэвийн бус	275.7	2.5%	136.7	1.3%	(139.0)	-50.4%
Эргэлзээтэй	28.5	0.3%	183.8	1.7%	155.3	544.8%
Муу	16.0	0.1%	21.1	0.2%	5.2	32.3%
(Факторингийн авлагын эрсдэлийн сан)	115.1	1.1%	155.6	1.5%	40.5	35.2%

Өмчлөх бусад үл хөдлөх болон өмчлөх бусад хөрөнгө

Өмчлөх бусад үл хөдлөх болон өмчлөх бусад хөрөнгийн дүн өмнөх оны мөн үеэс 7.2 тэрбум төгрөг буюу 58.4 хувиар өсөж 19.7 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй гарчээ.

Хүснэгт 15 ӨБҮХХ болон ӨБХ-ийн бүтэц /сая төгрөгөөр/

	Нийт	Итгэлцэл	Уламжлалт	Финтек	УБ	ХОН	ХК	ХХК	ГХО
ӨБҮХХ БОЛОН ӨБХ (ЦЭВРЭЭР)	19,666.2	7,762.5	16,091.6	3,574.6	19,094.7	571.5	335.0	19,331.2	1,399.9
Өмчлөх бусад үл хөдлөх хөрөнгө	23,343.2	10,023.9	16,604.7	6,738.4	23,195.2	148.0	2,121.1	21,222.1	2,496.0
(ӨБҮХХ-ийн болзошгүй эрсдэлийн сан)	8,702.6	5,294.9	5,463.8	3,238.8	8,702.6	-	1,786.1	6,916.6	1,697.5
Өмчлөх бусад хөрөнгө	5,025.7	3,033.5	4,950.7	75.0	4,602.2	423.5	-	5,025.7	601.4

Зээл

Нийт зээлийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 51.0% буюу 900.2 тэрбум төгрөгөөр өсөж 2022 оны III улирлын байдлаар 2,666.1 тэрбум төгрөгт хүрсэн бөгөөд үүнд 142.1 тэрбум төгрөгийн эрсдэлийн сан байгуулж, 2,524.0 тэрбум төгрөгийн цэвэр зээлийн үлдэгдэлтэй гарсан байна.

Хүснэгт 16 Зээлийн бүтэц /тэрбум төгрөгөөр/


	Нийт	Итгэлцэл	Уламжлалт	Финтек	УБ	ХОН	ХК	ХХК	ГХО
ЗЭЭЛ (ЦЭВРЭЭР)	2,524.0	1,479.8	1,588.0	936.1	2,475.2	48.8	378.5	2,145.6	402.9
Нийт зээл	2,666.1	1,548.3	1,687.4	978.7	2,611.9	54.3	393.3	2,272.9	419.0
Хэвийн	2,360.3	1,397.8	1,485.6	874.7	2,313.3	47.0	360.5	1,999.9	383.7
Анхаарал хандуулах	111.1	57.9	68.0	43.0	110.0	1.1	11.6	99.5	11.6
Чанаргүй:	194.7	92.6	133.8	61.0	188.6	6.2	21.2	173.5	23.7
-Хэвийн бус	58.8	30.3	33.6	25.2	58.3	0.5	8.0	50.8	7.4
-Эргэлзээтэй	44.4	21.6	27.0	17.4	43.8	0.7	7.3	37.1	5.6
-Муу	91.5	40.6	73.2	18.4	86.6	5.0	5.9	85.6	10.7
(Зээлийн эрсдэлийн сан)	142.1	68.5	99.4	42.7	136.6	5.5	14.8	127.3	16.1
Нийт зээл (төгрөгийн)	2,589.8	1,489.8	1,642.0	947.8	2,535.8	54.0	364.6	2,225.1	384.9
Нийт зээл (валютын)	76.4	58.4	45.4	30.9	76.1	0.3	28.6	47.8	34.1
Зээлдэгчдийн тоо	1,644,423	644,657	325,855	1,318,568	1,626,718	17,705	209,842	1,434,581	136,369
- Иргэн	1,644,423	644,657	325,855	1,318,568	1,626,718	17,705	209,842	1,36,369	1,551,585
- Хуулийн этгээд	1,627	556	1,351	276	1,577	50	205	282	887

/Финтек ББСБ-ууд уламжлалт зээл давхар олгодог болно/

Тайлант улиралд ББСБ-ууд 3.4 их наяд төгрөгийн зээлийг 3.1 хувийн жигнэсэн дундаж хүүтэйгээр олгож, 2.8 их наяд төгрөгийн зээл эргэн төлөгдөж, 2022 оны III улирлын байдлаар 1,644,423 зээлдэгчийн 2.7 их наяд төгрөгийн зээлийн үлдэгдэлтэй гарсан байна.

Нийт зээлийн үлдэгдлийн 88.5 хувийг буюу 2.4 их наяд төгрөгийг хэвийн зээл, 4.2 хувийг буюу 111.1 тэрбум төгрөгийг анхаарал хандуулах зээл, 7.3 хувийг буюу 194.7 тэрбум төгрөг чанаргүй зээлийн үлдэгдэл бүрдүүлж байна.

Зураг 3 Зээлийн багцын чанар /тэрбум төгрөгөөр/




Нийт зээлд эзлэх хэвийн болон чанаргүй зээлийн хэмжээ өмнөх оны мөн үеэс харгалзан 0.3, 1.0 пунктээр тус тус буурсан бол чанаргүй зээлийн хэмжээ 1.3 пунктээр өссөн байна. Анхаарал хандуулах болон чанаргүй зээлийн 305.8 тэрбум төгрөгийн үлдэгдлийн 46.5%-д буюу 142.1 тэрбум төгрөгийн зээлийн эрсдэлийн сан байгуулсан байна.

Сангийн сайд, Үндэсний статистикийн хорооны дарга нарын хамтарсан 2018 оны 12-р сарын 31-ний өдрийн 319/А/16 тоот тушаалаар баталсан “Эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны салбарын ангилал”-аар нийт олгосон зээлийн 75.8% буюу 2.6 их наяд төгрөг нь бусад ангилалд /ихэвчлэн хэрэглээний зээл/, 8.5% буюу 287.2 тэрбум төгрөг нь бөөний болон жижиглэн худалдааны салбарт олгогдсон бол нийт төлөгдсөн зээлийн 75.6% буюу 2.1 их наяд төгрөг нь бусад ангиллын зээлээс, 8.2% буюу 224.3 тэрбум төгрөг нь бөөний болон жижиглэн худалдааны салбарт олгосон зээлээс эргэн төлөгджээ.

2022 оны III улирлын байдлаар нийт зээлд эзлэх анхаарал хандуулах болон чанаргүй зээлийн хэмжээ 11.5% байна.

Зураг 4 Зээлийн багцын чанар /хувиар/




Олгосон зээлийн 92.1% буюу 3.1 их наяд төгрөгийн зээлийг иргэдэд, 7.9% буюу 269.4 тэрбум төгрөгийн зээлийг хуулийн этгээдэд олгосон байгаа бол 91.9% буюу 2.5 их наяд төгрөг нь иргэдээс, 8.1% нь буюу 221.5 тэрбум төгрөг нь хуулийн этгээдээс эргэн төлөгдсөн байна.

Хүснэгт 17 Олгосон болон төлөгдсөн зээл салбараар /сая төгрөгөөр/

№	Зээлийн эдийн засгийн ангилал	Олгосон зээл		Төлөгдсөн зээл		Зээлийн үлдэгдэл	
		Дүн	Хувь	Дүн	Хувь	Дүн	Хувь
1.	Хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур	20,380.3	0.6%	17,108.7	0.6%	29,297.5	1.1%
2.	Уул уурхай, олборлолт	26,550.8	0.8%	28,565.3	1.0%	43,560.8	1.6%
3.	Боловсруулах үйлдвэрлэл	28,986.6	0.9%	25,583.5	0.9%	32,916.3	1.2%
4.	Цахилгаан, хий, уур, агааржуулалтын хангамж	12,372.5	0.4%	2,009.1	0.1%	13,291.6	0.5%
5.	Усан хангамж, бохир ус, хог хаягдлын менежмент болон цэвэрлэх үйл ажиллагаа	2,030.7	0.1%	2,367.5	0.1%	2,088.9	0.1%
6.	Барилга	139,764.1	4.1%	115,799.7	4.2%	204,895.3	7.7%
7.	Бөөний болон жижиглэн худалдаа	287,249.3	8.5%	224,290.1	8.2%	323,656.3	12.1%
8.	Машин мотоциклийн засвар үйлчилгээ	96,072.3	2.8%	82,589.9	3.0%	98,777.8	3.7%
9.	Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа	36,748.2	1.1%	22,976.3	0.8%	37,577.6	1.4%
10.	Байр сууц болон хоол хүнсээр үйлчлэх үйл ажиллагаа	50,152.0	1.5%	37,647.0	1.4%	94,753.4	3.6%
11.	Мэдээлэл холбоо	7,729.1	0.2%	5,729.8	0.2%	8,720.2	0.3%
12.	Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа	59,510.8	1.8%	52,552.1	1.9%	40,120.6	1.5%
13.	Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа	8,475.4	0.2%	7,995.5	0.3%	15,665.8	0.6%
14.	Мэргэжлийн, шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа	2,305.4	0.1%	2,446.5	0.1%	4,922.0	0.2%
15.	Захиргааны болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа	19,805.4	0.6%	14,695.7	0.5%	21,243.5	0.8%
16.	Төрийн удирдлага ба батлан хамгаалах үйл ажиллагаа, албан журмын нийгмийн хамгаалал	1,421.6	0.0%	1,054.6	0.0%	1,658.9	0.1%
17.	Боловсрол	11,252.6	0.3%	8,233.4	0.3%	10,722.3	0.4%
18.	Хүний эрүүл мэнд, нийгмийн үйл ажиллагаа	12,404.6	0.4%	12,936.4	0.5%	13,157.6	0.5%
19.	Бусад	2,574,545.9	75.8%	2,060,667.3	75.6%	1,669,103.9	62.6%
	<i>Иргэнд олгосон зээл</i>	3,128,385.1	92.1%	2,503,706.6	91.9%	2,369,194.5	88.9%
	<i>Хуулийн этгээдэд олгосон зээл</i>	269,372.7	7.9%	221,541.5	8.1%	296,935.6	11.1%
	НИЙТ	3,397,757.8	100.0%	2,725,248.1	100.0%	2,666,130.1	100.0%

Тайлант улиралд олгосон 2.4 их наяд төгрөгийн зээлийг хугацааны ангиллаар харвал 1-2.5 жилийн хугацаатай олгосон зээл нийт зээлийн 24.5 хувийг, 6-12 сарын хугацаатай олгосон зээл нийт зээлийн 18.6 хувийг буюу хамгийн өндөр хувийг бүрдүүлж байна.

Зураг 5 Олгосон зээл /хугацааны ангиллаар/



Нийт зээлийн үлдэгдлийн ангиллаас харахад 2.7 их наядын зээлийн 57.9 хувийг иргэнд олгосон хэрэглээний зээл, 23.2 хувийг автомашинд зориулсан зээл 9.1 хувийг хуулийн этгээдэд олгосон бизнесийн зээл бүрдүүлж байна.

Хүснэгт 18 Зээлийн ангилал /тэрбум төгрөгөөр/

Зээлийн ангиллаар	Олгосон зээл		Төлөгдсөн зээл		Зээлийн үлдэгдэл	
	Дүн	Нийт дүнд эзлэх хувь	Дүн	Нийт дүнд эзлэх хувь	Дүн	Нийт дүнд эзлэх хувь
Иргэнд олгосон зээл	3,128.4	92.1%	2,503.7	91.9%	2,369.2	88.9%
Хэрэглээнд зориулсан зээл	2,424.6	71.4%	1,968.1	72.2%	1,542.8	57.9%
Үүнээс: Автомашинд зориулсан зээл	585.9	17.2%	360.9	13.2%	618.5	23.2%
Бизнес зориулсан зээл	406.5	12.0%	305.1	11.2%	476.1	17.9%
Үл хөдлөх эд хөрөнгөд зориулсан зээл	89.5	2.6%	72.1	2.6%	160.5	6.0%
Бусад зээл	207.8	6.1%	158.5	5.8%	189.8	7.1%
Хуулийн этгээдэд олгосон зээл	269.4	7.9%	221.5	8.1%	296.9	11.1%
Бизнесийн зээл	221.7	6.5%	181.8	6.7%	242.5	9.1%
Автомашин зээл	5.0	0.1%	7.6	0.3%	9.3	0.3%
Үл хөдлөх эд хөрөнгийн зээл	8.6	0.3%	5.5	0.2%	11.0	0.4%
Бусад зээл	34.0	1.0%	26.7	1.0%	34.1	1.3%
НИЙТ	3,397.8	100.0%	2,725.2	100.0%	2,666.1	100.0%

Цахим зээл

Санхүүгийн үйлчилгээнд техник технологийг ашиглаж, шинэ төрлийн үйлчилгээ бий болгон, уламжлалт зээлийн үйлчилгээг хялбар, түргэн, шуурхай болгож буй онлайн зээлийн үйлчилгээг 2022 оны III улирлын байдлаар 36 ББСБ үзүүлж байна.

Хүснэгт 19 Зээлийн ангилал

	Зээлийн дүн	Нийт дүнд эзлэх хувь	Зээлдэгчдийн тоо	Нийт дүнд эзлэх хувь	Дундаж зээл
Уламжлалт	2,319,320,999.5	87.0%	184,047	11.2%	12,601.8
Цахим зээл	346,809,088.7	13.0%	1,460,376	88.8%	237.5
Нийт	2,666,130,088.2	100.0%	1,644,423	100.0%	1,621.3

Эдгээрийн 5 ББСБ нь зөвхөн аппликэйшн ашиглан зээл олгож байгаа бол 31 ББСБ нь уламжлалт болон финтекийг хослуулан зээл болон бусад төрлийн санхүүгийн үйлчилгээг санал болгож байна. 2022 оны III улирлын байдлаар эдгээр ББСБ-ууд зөвхөн аппликэйшний 1,460,376 зээлдэгчийн 346.8 тэрбум төгрөгийн зээлийн үлдэгдэлтэй байгаа нь нийт зээлдэгчийн 88.8 хувь, нийт зээлийн үлдэгдлийн 13.0 хувийг бүрдүүлж байна. Нэг зээлдэгчид дунджаар 237.5 мянган төгрөгийн зээл олгосон байгаа нь уламжлалт зээлийн дунджаас 53.1 дахин бага байна.

Хүснэгт 20 Цахим зээл олгож байгаа ББСБ-ууд

№	Финтек	Апп нэр
1	Мобифинанс	Monpay
2	Тус финтек	TUS Fintech
3	Эм Пи Эс Си	Toki
4	Инвескор хэтэвч	Pocket
5	Кэйш флов финанс	Tugrug app
6	Ашид капитал	Simple, Simple Agent
7	Лэндмн	LendMN
8	Таван богд финанс	PayOn.mn
9	Нөмөр кредит	numur
10	Соно финтек	Sono Mongolia
11	Ардкредит	Ard
12	Сэндли	Hi-PayMerchant, Hipay, Sendly
13	Омни капитал	Moni Digital
14	Бизнес-Инвест девелопмент	БИД app
15	Говьфинанс	CashOne Lite, CashOne
16	Хатан суудал инвест	Zeely
17	Нэт капитал финанс корпораци	Net app
18	Энт кредит инвестмент	EntcreditMN
19	Ньюстар финанс	Nsf.mn, Lite+
20	Шинэхэн инвест	www.bayan.mn
21	Очир ундраа ОМЗ	Opay
22	Грийн финтек	t finance green fintech
23	Зээл Эм Эн платформ	Zeel.mn
24	Жи Эс Би Капитал	GSB Prime
25	Грийн-Инвестмент	Gate.mn
26	Цогзолфинанс	Pocket
27	Начин заан финанс	Naizly
28	Нанокапитал	Nano Capital
29	Мөнгөнзоос кредит	Pocket
30	Хас хаан	ХАСХААН
31	Монголиа импакт финанс	Qmoni
32	Фин экспресс	Finex
33	Смарткапитал фонд	My Credit
34	Нэмэх төгрөг	Most Money
35	Өсөх ундарга финанс	ufinance
36	Солонго капитал	100k.mn
Зөвшөөрөлгүй аппликэйшнүүд		
1	Би энд жи финанс	Lemond
2	Магна профит энд инвестмент	magna.mn
3	Номинкарт	Omniway
4	Франкфурт капитал	Nar app
5	Гурван зуун жар финанс	Minu pay
6	Гэрэлфинанс	Gerel
7	Микрокредит	Microcredit
8	Их монгол кредит	Ih mongol credit
9	Дэвжих нэхий	Money-T

10	Онч-Энх	Ugloo
11	Нэйшнл кредит юнион	Tenlend
Валют арилжаа явуулдаг		
1	Сэнд эм эн	SendMN
2	Би Ар системс	Moex
3	Инвестос	Most Money
4	Файнэншилтрипл групп	WX
Нийт		

Санхүүгийн зохицуулах хорооны 2022 оны 04 дүгээр сарын 06-ны өдрийн 160 дугаар тогтоолоор “[Банк бус санхүүгийн зээлийн үйл ажиллагааны журам](#)”-ыг баталсан. Уг журам нь Хууль зүйн яамны Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд 2022 оны 4 дүгээр сарын 28-ны өдрийн 5807 дугаарт бүртгэгдэж, [Захиргааны хэм хэмжээний актын эмхэтгэлийн 2022 оны 13 дугаарт](#) нийтлэгдсэнээр финтек зээл олгож байгаа ББСБ-уудын эрх зүйн орчин бүрдсэн.

Энэхүү журам батлагдахаас өмнө финтек зээлийн үйлчилгээ эрхэлж байсан 36 ББСБ нь дээрх тогтоолын 3-т заасны дагуу 2022 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн дотор журамд заасан шаардлагыг ханган Санхүүгийн зохицуулах хороонд бүртгүүлэхийг үүрэг болгосон.

Хүснэгт 21 Зөвшөөрөлгүй финтек зээлийн аппликэйшнууд:

	Хөгжүүлэгч	Апп нэр
1	Duu lekh GB capital llc	Duulekh
2	GTC 6655009	Rain Fintech
3	Kheregleenii leasing llc	eLeasing
4	Momoland llc	momoland
5	Next solution	Нэр
6	Region invest	Easyloan MN
7	Sukhes usukh llc	Niszeel.mn
8	Tanasoft	Goodlend
9	Tanasoft	iLend
10	Tanasoft	Me app mongolia
11	Tanasoft	Yolapp
12	Tanasoft	Amiya
13	Tanasoft	Oneclick.mn
14	Unlock fintech	eZeel
15	Unlock vision finance llc	Unlock finance
16	Дижитал кредит ХХК	Zeelme

Харин 2022 оны эхний хагас жилээс хойш финтек зээл олгож эхэлсэн ББСБ-ууд нь журмын 4 дүгээр бүлэгт заасан шаардлагуудыг хангасны дараагаар үйлчилгээ үзүүлэх эрхтэй болох тул дээрх 11 ББСБ нь зөвшөөрөлгүйгээр үйлчилгээ үзүүлж байгаа үзэн “Банк бус санхүүгийн байгууллагын үйл ажиллагаанд эрсдэлд суурилсан хяналт шалгалт хийх журам”-ын 6 дугаар бүлэгт заасан түдгэлзүүлэх, тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Ногоон зээл

Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилгаар 2022 оны 03 дугаар сарын 29, 30-ны өдрүүдэд зохион байгуулсан “Ногоон санхүүжилт – Бүс нутгийн чуулган”-аар уур амьсгалын өөрчлөлт, цөлжилт, газрын доройтлыг бууруулах чиглэлээр бүс нутгийн хамтын ажиллагааг эрчимжүүлэх, тулгамдсан асуудлыг шийдвэрлэх, тогтвортой, ногоон санхүүжилтийг хөгжүүлэх, “Ногоон хөгжлийн сэргэлтийн бодлого”-ыг хэрэгжүүлэх талаар хэлэлцэн, зөвлөмж гаргасан. Зөвлөмжийн 1 дүгээр бүлгийн 1.3-т “Ногоон зээлийг банкны салбарт 10 хувь, ББСБ-уудад 5 хувьд хүргэхэд шаардлагатай бодлогын арга хэмжээ авч хэрэгжүүлэх, ногоон зээлд эрсдэлийн сан байгуулах, хөнгөлөлт урамшуулал олгох, ногоон зээлийн эх үүсвэрийн свопын зардлыг бууруулах зэрэг хөшүүрэг бий болгох” үүргийг Санхүүгийн зохицуулах хороо хүлээсэн. Үүний дагуу 2022 оны II улирлаас эхлэн “Монгол Улсын Ногоон таксономи”-ийн үндсэн 8 ангиллын дагуу ББСБ-уудаас “Ногоон зээлийн тайлан”-г авч эхлээд байна.

❖ **Ногоон таксономи** гэдэг нь байгаль орчинд ээлтэй үйл ажиллагааны ангилал, тодорхойлолт, шалгуур үзүүлэлт бөгөөд банк, санхүүгийн байгууллагууд, хөрөнгө оруулагчид болон бодлого боловсруулагчид энэхүү таксономийг ногоон зээл, ногоон хөрөнгө оруулалтын төсөл, хөтөлбөрүүдийг тодорхойлохдоо ашиглана. Ногоон таксономи нь аль нэг салбараар хязгаарлагдахгүй, бизнесийн бүхий л салбарыг хамаарах шалгуур үзүүлэлт юм.

Тайлант хугацаанд 18 ББСБ 2,490 зээлдэгчид 48.9 тэрбум төгрөгийн зээлийг дунджаар 2.6 хувийн хүүтэйгээр олгож, 18 ББСБ-ын 4,789 зээлдэгчээс 19.7 тэрбум төгрөгийн зээл эргэн төлөгдөж, 2022 оны III улирлын байдлаар 21 ББСБ 4,102 зээлдэгчийн 78.3 тэрбум төгрөгийн “**ногоон**” зээлийн үлдэгдэлтэй гарчээ. Энэ нь салбарын нийт зээлийн үлдэгдлийн 2.9%-тай тэнцэж байна.


Хүснэгт 22 Ногоон зээлийн тайлан /сая төгрөгөөр/

НОГООН ТАКСОНОМИ ҮНДСЭН 8 АНГИЛАЛ	Олгосон зээлийн		Төлөгдсөн зээлийн		Зээлийн эцсийн үлдэгдлийн	
	Дүн	Зээлдэгчдийн тоо	Дүн	Зээлдэгчдийн тоо	Дүн	Зээлдэгчдийн тоо
1. СЭРГЭЭГДЭХ ЭРЧИМ ХҮЧ	-	-	-	-	-	-
2. БАГА БОХИРДУУЛАГЧ ЭРЧИМ ХҮЧ	-	-	124.0	2.0	125.0	1.0
3. ЭРЧИМ ХҮЧНИЙ ХЭМНЭЛТ	-	-	2.0	1.0	5.1	6
4. НОГООН БАРИЛГА	1,915.8	185.0	1,077.7	77.0	6,358.1	825
5. БОХИРДЛООС СЭРГИЙЛЭХ, БУУРУУЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА	210.9	51.0	174.5	50.0	193.1	50.0
6. ТОГТВОРТОЙ УС, ХАЯГДЛЫН ХЭРЭГЛЭЭ	-	-	-	-	-	-
7. ТОГТВОРТОЙ ХӨДӨӨ АЖ АХУЙ, ГАЗАР АШИГЛАЛТ, ОЙ БОЛОН ЭКО АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ	16,684.5	9.0	264.6	5.0	16,970.4	13.0
8. КАРБОН БАГА ЯЛГАРУУЛДАГ ТЭЭВЭР	30,117.3	2,245.0	18,070.6	4,654.0	54,670.3	3,207.0
Үүнээс:						
0-5 хүртэлх жилийн ашиглалтын жилтэй тээвэр	58.5	4.0	12.0	5.0	122.8	2.0
5-10 хүртэлх жилийн ашиглалтын жилтэй тээвэр	22,276.2	1,480.0	12,632.8	3,531.0	34,290.7	1,868.0
10-аас дээш жилийн ашиглалтын жилтэй тээвэр	7,782.6	761.0	5,425.8	1,118.0	20,256.8	1,337.0
НИЙТ	48,928.5	2,490.0	19,713.5	4,789.0	78,322.0	4,102.0

Ногоон зээлийн үлдэгдлийн 69.8% буюу 54.7 тэрбум төгрөгийг карбон бага ялгаруулдаг тээврийн хэрэгслийн зээлийн үлдэгдэл бүрдүүлж байна. Сэргээгдэх эрчим хүч, тогтвортой ус, хаягдлын хэрэглээний салбаруудад зээлийн үлдэгдэл байхгүй байна.

Нийт зээлийн үлдэгдлийн 94.9% нь хэвийн, 3.1% нь анхаарал хандуулах, 1.9% нь чанаргүй ангилалд ангилагдсан ба Ногоон барилгын салбарын зээлийн үлдэгдэл хамгийн их буюу 3.1% нь чанаргүй ангилалд ангилагдсан байна.

Зураг 6 Ногоон зээлийн багцын чанар /ногоон таксономийн 8 ангиллаар/



Бусад хөрөнгө

2022 оны III улирлын байдлаарх 322.1 тэрбум төгрөгийн бусад хөрөнгийн үлдэгдлийн 37.2% буюу 119.9 тэрбум төгрөг нь хуримтлуулж тооцсон хүүгийн авлага, 38.3% буюу 123.4 тэрбум төгрөг нь дансны цэвэр авлага, 24.5% буюу 78.8 тэрбум төгрөг нь бусад актив байна.

Хүснэгт 23 Бусад хөрөнгийн бүтэц /сая төгрөгөөр/

	Нийт	Итгэлцэл	Уламжлалт	Финтек	ЗГВА	УБ	ХОН	ХК	ГХО
БУСАД ХӨРӨНГӨ	322,144.1	168,979.3	233,792.0	88,352.1	215.8	316,923.2	5,220.9	51,738.4	49,847.1
Хуримтлуулж тооцсон хүүгийн авлага	119,887.5	57,230.3	92,250.8	27,636.7	-	118,103.0	1,784.5	9,951.9	19,166.7
-Үнэт цаасны	1,129.2	1,129.2	-	1,129.2	-	1,129.2	-	92.9	-
-Зээлийн	116,133.9	54,546.5	90,489.3	25,644.6	-	114,365.8	1,768.1	9,400.9	19,081.4
-Факторингийн	244.5	208.1	24.9	219.6	-	244.5	-	-	-
-Бусад	2,379.8	1,346.6	1,736.6	643.2	-	2,363.5	16.3	458.1	85.2
Авлага /цэврээр/	123,427.8	88,095.6	84,550.8	38,877.1	6.4	120,994.7	2,433.1	33,823.5	6,326.5
Нийт авлага	126,503.4	90,390.8	86,820.2	39,683.2	6.4	124,064.6	2,438.8	34,324.2	7,471.2
Хэвийн	120,442.4	87,856.1	81,683.7	38,758.7	2.9	118,017.1	2,425.3	33,811.6	6,505.1
Хугацаа хэтэрсэн	136.2	50.1	68.7	67.5	3.5	127.9	8.3	5.6	9.3
Чанаргүй:	5,924.8	2,484.6	5,067.9	856.9	-	5,919.5	5.2	507.1	956.7
-Хэвийн бус	56.7	50.0	11.7	45.0	-	56.7	-	5.3	7.5
-Эргэлзээтэй	49.8	48.1	6.0	43.8	-	49.8	-	5.4	5.3
-Муу	5,818.3	2,386.5	5,050.2	768.1	-	5,813.0	5.2	496.3	944.0
Нийт авлага (валютын)	100,840.3	65,281.9	61,776.1	39,064.2	6.4	98,401.5	2,438.8	34,317.1	7,471.1
Нийт авлага (төгрөгийн)	25,663.1	25,108.8	25,044.2	618.9	-	25,663.1	-	7.1	0.1
(Авлагын эрдэлийн сан)	3,075.5	2,295.2	2,269.5	806.1	-	3,069.9	5.7	500.7	1,144.7
Бусад актив	78,828.8	23,653.4	56,990.5	21,838.3	209.4	77,825.5	1,003.4	7,962.9	24,354.0

Эргэлтийн бус хөрөнгө

ББСБ-ууд 2022 оны III улирлын байдлаар 138.8 тэрбум төгрөгийн үндсэн хөрөнгийн үлдэгдэлд 32.2 тэрбум төгрөгийн элэгдлийг хуримтлуулж бүртгэсэн байна. Ингэснээр тайлант хугацаанд 106.6 тэрбум төгрөгийн биет ба биет бус хөрөнгийн үлдэгдэлтэй гарсан байна.

Хүснэгт 24 Эргэлтийн бус хөрөнгийн бүтэц /тэрбум төгрөгөөр/

ҮНДСЭН (БИЕТ) БА БИЕТ БУС ХӨРӨНГӨ (ЦЭВРЭЭР)	Нийт	Итгэлцэл	Уламжлалт	Финтек	ЗГВА	УБ	ХОН	ХК	ГХО
106.6	52.9	64.7	41.9	0.4	104.0	2.6	8.8	9.7	
Үндсэн /биет/ ба биет бус хөрөнгө	138.8	69.0	87.3	51.5	0.5	135.2	3.6	13.1	14.2
Барилга байгууламж	48.3	30.6	24.0	24.4	0.1	47.1	1.3	2.2	1.9
Техник хэрэгсэл	48.6	16.9	38.2	10.5	0.1	46.8	1.8	3.0	4.5
Тавилга эд хогшил	16.7	9.1	12.1	4.5	0.2	16.3	0.4	3.2	3.8
Дуусаагүй барилга	6.8	2.4	4.7	2.1	0.0	6.7	0.0	0.1	0.3
Биет бус хөрөнгө	18.4	9.9	8.4	10.0	0.2	18.4	0.1	4.6	3.7
(Хуримтлагдсан элэгдэл)	32.2	16.1	22.6	9.6	0.1	31.2	1.1	4.2	4.4
Барилга байгууламжийн	6.7	4.4	2.9	3.8	0.0	6.5	0.2	1.1	0.1
Техник хэрэгслийн	17.6	7.0	14.0	3.7	0.0	16.9	0.7	1.3	2.2
Тавилга эд хогшлын	8.0	4.7	5.8	2.1	0.1	7.8	0.2	1.8	2.1

Пассивын бүтэц, бүрэлдэхүүн, өөрчлөлт


Салбарын нийт пассив өмнөх оны мөн үеэс 38.2 хувиар буюу 940.7 тэрбум төгрөгөөр өссөн ба энэхүү өсөлтийн 53.0 хувийг өр төлбөрийн өсөлт, 47.0 хувийг өөрийн хөрөнгийн өсөлт бүрдүүлж байна. Пассивын үзүүлэлтүүдийг өмнөх оны мөн үетэй харьцуулж үзвэл:

Хүснэгт 25 Пассивын үзүүлэлтүүд /сая төгрөгөөр/

Пассивын үзүүлэлтүүд	2021-III	Нийт дүнд эзлэх хувь	2022-III	Нийт дүнд эзлэх хувь	Өөрчлөлт	
	дүн		дүн		дүн	хувь
Өр төлбөр	777,989.0	31.6%	1,276,124.8	37.5%	498,135.8	64.0%
Санхүүгийн эх үүсвэр	216,505.9	8.8%	354,036.2	10.4%	137,530.3	63.5%
Дотоод, гадаадын банк, санхүүгийн байгууллагад төлөх өглөг	219,066.5	8.9%	407,190.3	12.0%	188,123.7	85.9%
Бусад эх үүсвэр	47,984.2	2.0%	53,673.0	1.6%	5,688.8	11.9%
ББСБ-аас гаргасан өрийн бичиг	116,298.2	4.7%	200,226.6	5.9%	83,928.3	72.2%
Төслийн зээлийн санхүүжилт	15,226.7	0.6%	19,352.7	0.6%	4,126.0	27.1%
Бусад өр төлбөр	162,907.4	6.6%	241,646.0	7.1%	78,738.6	48.3%
Эздийн өмч	1,682,121.4	68.4%	2,124,668.4	62.5%	442,547.0	26.3%
Хувьцаат капитал	1,078,419.5	43.8%	1,275,500.4	37.5%	197,080.9	18.3%
Бусад өмч	53,254.6	2.2%	60,994.4	1.8%	7,739.8	14.5%
Сангууд	1,012.1	0.0%	2,690.1	0.1%	1,677.9	165.8%
Хуримтлагдсан ашиг/алдагдал	504,103.6	20.5%	714,938.5	21.0%	210,834.9	41.8%
Хоёрдогч өглөг	45,331.6	1.8%	70,545.0	2.1%	25,213.4	55.6%
Нийт өр төлбөр ба өөрийн хөрөнгийн дүн	2,460,110.4	100.0%	3,400,793.2	100.0%	940,682.8	38.2%

Сүүлийн 5 жилийн пассивын үзүүлэлтийг харвал салбарын нийт хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ 2018 оны мөн үед 1.2 их наяд төгрөг байсан бол 2022 оны III улирлын байдлаар 2.8 дахин өсөж 3.4 их наяд төгрөгт, өр төлбөрийн хувьд 4.7 дахин өсөж 1.3 их наяд төгрөгт хүрсэн байна.


Зураг 7 Пассивын үзүүлэлтүүд сүүлийн 5 жилийн байдлаар /тэрбум төгрөгөөр/



Санхүүгийн эх үүсвэр

2022 оны III улирлын байдлаар итгэлцлийн үйлчилгээний өглөг өмнөх оны мөн үеэс 63.5% буюу 137.5 тэрбум төгрөгөөр өсөж, итгэлцлийн үйлчилгээний тусгай зөвшөөрөлтэй 61 ББСБ-аас 56 ББСБ 5,584 итгэмжлэгчээс 354.0 тэрбум төгрөгийн итгэлцэл татан төвлөрүүлсэн байна.

Зураг 8 Итгэлцлийн үйлчилгээний өглөг /тэрбум төгрөгөөр/



Улаанбаатар хотын 55 ББСБ 5,575 итгэмжлэгчээс 352.6 тэрбум төгрөг, хөдөө орон нутгийн 1 ББСБ 9 итгэмжлэгчээс 1.4 тэрбум төгрөгийн хөрөнгө татан төвлөрүүлсэн байна.

Хүснэгт 26 Итгэлцлийн үйлчилгээ /тэрбум төгрөгөөр/

Итгэлцлийн үйлчилгээний өглөг	Дүн	Уламжлалт	Финтек	УБ	ХОН	ХК	ХХК	ГХО
Итгэлцлийн үйлчилгээний өглөг	354.0	179.8	174.2	352.6	1.4	115.1	239.0	94.4
-Төгрөгөөр	302.5	158.0	144.6	352.6	1.4	115.1	187.4	94.4
-Валютаар	51.5	21.9	29.6	301.1	1.4	92.6	(41.1)	77.9
Итгэлцлийн үйлчилгээний тусгай зөвшөөрөлтэй ББСБ-ын тоо	61	45	16	60	1	5	56	6
-Үүнээс итгэлцлийн үйлчилгээний өглөгтэй ББСБ-уудын тоо	56	40	16	55	1	5	51	5
Нийт итгэмжлэгчдийн тоо	5,584	3,017	2,567	5,575	9	1,118	4,466	289

Хамгийн өндөр дүнгээр буюу 80.0 тэрбум төгрөгийг 189 итгэмжлэгчээс татан төвлөрүүлсэн бол хамгийн олон буюу 2,262 итгэмжлэгчээс 762.3 сая төгрөгийг татан төвлөрүүлсэн байна.

Дотоод, гадаадын банк, санхүүгийн байгууллагад төлөх өглөг

2022 оны III улирлын байдлаар дотоод, гадаадын банк, санхүүгийн байгууллагад төлөх өглөг 85.9 хувиар өсөж, 99 ББСБ дотоод, гадаадын банк болон санхүүгийн байгууллагаас 354.0 тэрбум төгрөгийн эх үүсвэр татан төвлөрүүлж үйл ажиллагаандаа ашиглаж байна.

Хүснэгт 27 Дотоод, гадаадын банк, санхүүгийн байгууллагад төлөх өглөг /тэрбум төгрөгөөр/

Банк, санхүүгийн байгууллагад төлөх өглөг	Дүн	Нийт дүнд эзлэх хувь	Итгэлцэл	Уламжлалт	Финтек	УБ	ХОН	ХК	ХХК	ГХО
Банк, санхүүгийн байгууллагад төлөх өглөг	407.2		309.4	247.3	159.9	404.9	2.3	92.2	315.0	104.3
Хугацаагаар:										
Богино хугацаат зээл	183.8	45.1%	150.4	130.4	53.4	183.1	0.7	37.3	146.5	42.4
Урт хугацаат зээл	223.4	54.9%	158.9	116.9	106.5	221.8	1.7	54.9	168.6	61.9
Валютын төрлөөр:										
Төгрөгөөр	324.2	79.6%	250.2	189.0	135.2	321.9	2.3	73.9	250.3	71.6
Валютаар	83.0	20.4%	59.2	58.3	24.7	83.0	-	18.3	64.7	32.7
Зээл авсан байгууллагаар:										
Дотоодын банк, санхүүгийн байгууллагаас	330.7	81.2%	255.9	193.8	137.0	328.4	2.3	79.6	251.2	75.7
Зээл /төгрөгөөр/	324.2	79.6%	250.2	189.0	135.2	321.9	2.3	73.9	250.3	71.6
Зээл /валютаар/	6.6	1.6%	5.7	4.8	1.8	6.6	-	5.7	0.9	4.1
Гадаадын банк, санхүүгийн байгууллагаас	76.4	18.8%	53.5	53.6	22.9	76.4	-	12.6	63.9	28.6

Бусад эх үүсвэр

2022 оны III улирлын байдлаар 17 ББСБ 53.7 тэрбум төгрөгийн бусад эх үүсвэрийн үлдэгдэлтэй гарчээ. Үүнээс нэр бүхий 6 ББСБ 12.3 тэрбум төгрөгийн мөнгөн гуйвуулгын үйлчилгээний өглөгийн үлдэгдэлтэй, нэр бүхий 3 ББСБ 1.8 тэрбум төгрөгийн төлбөр тооцооны үйлчилгээний өглөгийн үлдэгдэлтэй, нэр бүхий 8 ББСБ 39.6 тэрбум төгрөгийн факторингийн үйлчилгээний өглөгтэй гарчээ. Мөн 1 ББСБ 112.5 мянган төгрөгийн гадаад валютын арилжааны эх үүсвэрийн үлдэгдэлтэй гарсан байна.

Хүснэгт 28 Бусад эх үүсвэрийн бүтэц /сая төгрөгөөр/

Бусад эх үүсвэр	Дүн	Эзлэх хувь	Итгэлцэл	Уламжлалт	Финтек	УБ	ХК	ХХК
Нийт	53,673.0	100.0%	38,983.4	37,926.3	15,746.7	53,673.0	200.3	53,472.7
Мөнгөн гуйвуулгын үйлчилгээний өглөг	12,312.6	22.9%	8,561.4	2,505.5	9,807.2	12,312.6	200.3	12,112.3
Төлбөр тооцооны үйлчилгээний өглөг	1,758.8	3.3%	224.7	1,534.1	224.7	1,758.8	-	1,758.8
Факторингийн үйлчилгээний өглөг	39,601.5	73.8%	30,197.4	33,886.6	5,714.8	39,601.5	-	39,601.5
Гадаад валютын арилжааны эх үүсвэр	0.1	0.0%	-	0.1	-	0.1	-	-

Өмнөх оны мөн үеэс мөнгөн гуйвуулгын үйлчилгээний өглөг 6.0 хувиар, факторингийн үйлчилгээний өглөг 9.6 хувиар өссөн бол төлбөр тооцооны үйлчилгээний өглөг 8.2 дахин өссөн байна. Иймд төлбөр тооцооны үйлчилгээний өглөгийн үлдэгдэлтэй 3 ББСБ-ыг

Зураг 9 Бусад эх үүсвэрийн үлдэгдэлтэй ББСБ-ууд /мянган төгрөгөөр/

Бусад эх үүсвэр	2018.Ш	2019.Ш	2020.Ш	2021.Ш	2022.Ш
Зээлийн батлан даалтад байршуулсан эх үүсвэр	-	-	55,000.0	-	-
Мөнгөн гуйвуулгын үйлчилгээний өглөг	6,062,599.6	2,858,778.7	7,951,349.2	11,620,642.7	12,312,637.6
Төлбөр тооцооны үйлчилгээний өглөг	3,343,039.9	4,059,710.0	230,756.4	215,738.7	1,758,815.8
Факторингийн үйлчилгээний өглөг	-	8,134,245.2	34,703,559.9	36,147,797.4	39,601,456.5
Гадаад валютын арилжааны эх үүсвэр	-	-	-	-	112.5
Нийт	9,405,639.5	15,052,733.9	42,940,665.5	47,984,178.8	53,673,022.5

Хөдөө орон нутагт үйл ажиллагаа эрхэлж байгаа болон гадаадын хөрөнгө оруулалттай ББСБ-уудаас бусад эх үүсвэрийн үлдэгдэлтэй ББСБ байхгүй байна.

ББСБ-аас гаргасан өрийн бичиг


Хүснэгт 29 ББСБ-аас гаргасан өрийн бичиг /мянган төгрөгөөр/

ББСБ-ААС ГАРГАСАН ӨРИЙН БИЧИГ	Дүн	Итгэлцэл	Уламжлалт	Финтек	УБ	ХОН	ХК	ХХК	ГХО
	Нийт	200,226.6	134,748.9	61,774.3	138,452.3	199,371.3	855.3	42,666.3	157,560.3
Төгрөгөөр	189,500.4	124,110.9	61,686.1	127,814.3	188,645.1	855.3	42,666.3	146,834.1	25,382.8
Валютаар	10,726.1	10,638.0	88.1	10,638.0	10,726.1	-	-	10,726.1	-


2022 оны III улирлын байдлаар 37 ББСБ нээлттэй болон хаалттай хүрээнд өрийн бичиг гаргаж, үүнийг 1,874 хувь хүн, хуулийн этгээд худалдан авсан ба нийт 200.2 тэрбум төгрөгийн өрийн бичгийн өглөгийн үлдэгдэлтэй байна.

Өрийн бичгийн үлдэгдэл 2018 оны мөн үеэс 9.5 дахин өсөж 200.2 тэрбум төгрөгт хүрсэн байна.

Зураг 10 Өрийн бичгийн үлдэгдэл сүүлийн 5 жилийн байдлаар /тэрбум төгрөгөөр/



Өмнөх оны мөн үед валютаар гаргасан өрийн бичгийн нийт өрийн бичгийн үлдэгдэлд эзлэх хувийн жин 7.1% байсан бол 2022 оны III улирлын 1.8 пунктээр буурч 5.4%-д хүрсэн байна.



Санхүүгийн зохицуулах хороонд бүртгэгдээгүй, 2022 оны III улирлын байдлаар санхүүгийн тайланд өрийн бичгийн үлдэгдэлтэй байгаа ББСБ-уудын журмын үйлчлэх хугацаанд өрийн бичиг шинээр болон нэмж гаргасан эсэхэд тэгш хяналт тавих шаардлагатай байна.

Төслийн зээлийн санхүүжилт

Төсөл хөтөлбөрөөс 10 ББСБ 19.3 тэрбум төгрөгийг төслийн санхүүжилтээр татан төвлөрүүлж үйл ажиллагаандаа ашиглаж байна.

Хүснэгт 31 Төслийн зээл санхүүжилт /сая төгрөгөөр/

ТӨСЛИЙН ЗЭЭЛИЙН САНХҮҮЖИЛТ	Дүн	Нийт дүнд эзлэх хувь	Итгэлцэл	Уламжлалт	Финтек	УБ	ХОН	ХК	ХХК	ГХО
	19,352.7		16,132.9	10,853.1	8,499.6	17,345.4	2,007.2	8,499.6	10,853.1	7,113.0
Хугацаагаар										
Богино хугацаат	8,651.5	44.7%	7,936.0	715.5	7,936.0	8,438.4	213.1	7,936.0	715.5	-
Урт хугацаат	10,701.2	55.3%	8,196.8	10,137.6	563.6	8,907.0	1,794.2	563.6	10,137.6	7,113.0
Төрлөөр										
Засгийн газрын	-	-	-	-	-	-	-	-	-	-
Гадаадын	15,532.5	80.3%	15,532.5	7,033.0	8,499.6	15,532.5	-	8,499.6	7,033.0	7,033.0
Дотоодын	3,471.5	17.9%	416.8	3,471.5	-	1,604.3	1,867.2	-	3,471.5	80.0
Бусад	348.7	1.8%	183.5	348.7	-	208.7	140.0	-	348.7	-
Валютын төрлөөр										
Төгрөгөөр	16,211.9	83.8%	12,992.1	7,712.3	8,499.6	14,204.6	2,007.2	8,499.6	7,712.3	3,972.2
Валютаар	3,140.8	16.2%	3,140.8	3,140.8	-	3,140.8	-	-	3,140.8	3,140.8

Бусад өр төлбөр

2022 оны III улирлын байдлаар 490 ББСБ 241.6 тэрбум төгрөгийн бусад өр төлбөрийн үлдэгдэлтэй байна. Үүний 17.8% буюу 43.0 тэрбум төгрөг нь хуримтлуулж тооцсон хүүгийн өглөг, 82.2% буюу 198.6 тэрбум төгрөг нь бусад пассив, 0.004% буюу 9.4 сая төгрөг нь санхүүгийн үүсмэл хэрэгсэл (дериватив)-ийн өглөгийн үлдэгдэл байна.

Хүснэгт 32 Бусад өр төлбөр /сая төгрөгөөр/

БУСАД ӨР ТӨЛБӨР	Дүн	Итгэлцэл	Уламжлалт	Финтек	ЗГВА	УБ	ХОН	ХК	ХХК	ГХО
	241,646.0	142,920.3	153,039.4	88,606.6	294.0	240,543.0	1,103.0	60,956.4	180,689.7	68,282.7
Хуримтлуулж тооцсон хүүгийн өглөг										
Ангиллаар										
Зээлийн	18,957.3	7,520.3	8,236.3	10,721.0	64.3	18,957.3	0.0	2,555.4	16,401.8	1,541.1
Үнэт цаасны	3,652.9	3,580.2	631.9	3,021.0	-	3,652.9	-	1,078.7	2,574.2	563.0
Бусад	20,388.7	17,429.2	7,852.4	12,536.3	-	20,380.5	8.1	6,038.4	14,350.3	4,835.3
Валютын төрлөөр										
Төгрөгөөр	40,010.9	25,866.3	15,446.4	24,564.5	64.3	40,002.8	8.1	9,066.9	30,944.0	6,241.6
Валютаар	2,987.9	2,663.5	1,274.2	1,713.7	-	2,987.9	-	605.6	2,382.3	697.7
Бусад пассив	198,637.9	114,381.2	136,318.8	62,319.1	229.7	197,543.0	1,094.9	51,283.9	147,354.0	61,343.4
Деривативийн өглөг	9.4	9.4	-	9.4	-	9.4	-	-	9.4	-

Хувь нийлүүлсэн хөрөнгө

Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 18.3% буюу 197.1 тэрбум төгрөгөөр өсөж 1.3 их наяд төгрөгт хүрсэн ба энэ нь нийт пассивын 37.5 хувийг бүрдүүлж байна.


Хүснэгт 33 Хувьцаат капиталын бүтэц /сая төгрөгөөр/

Хувьцаат капитал	Дүн	Итгэлцэл	Уламжлалт	Финтек	ЗГВА	УБ	ХОН	ХК	ХХК	ГХО
	1,275,500.4	374,683.0	1,013,815.7	261,684.7	20,146.4	1,224,721.6	50,778.8	36,038.1	1,239,462.3	104,824.8
Энгийн хувьцаа	1,277,655.3	377,201.2	1,013,632.8	264,022.5	20,146.4	1,226,918.8	50,736.5	38,379.4	1,239,275.9	104,707.4
Давуу эрхтэй хувьцаа	393.3	30.0	393.3	-	-	351.0	42.3	-	393.3	121.0
Халаасны хувьцаа	2,548.2	2,548.2	210.4	2,337.8	-	2,548.2	-	2,341.4	206.8	3.6

Хувьцаат капиталын хэмжээ 2018 оны мөн үеэс 1.8 дахин өсөж 1.3 их наяд төгрөгт, Үүнээс энгийн хувьцаа 1.8 дахин өсөж 1.3 их наяд төгрөгт, давуу эрхийн хувьцаа 47.5 хувиар буурч 393.3 сая төгрөгт, халаасны хувьцаа 1.2 дахин өсөж 2.5 тэрбум төгрөгт хүрсэн байна.

2022 оны III улирлын байдлаар 522 ББСБ-ын 1.3 их наяд төгрөгийн энгийн хувьцаа, 4 ББСБ-ын 393.3 сая төгрөгийн давуу эрхийн хувьцаа, 4 ББСБ-ын 2.5 тэрбум төгрөгийн халаасны хувьцаа бүртгэгдсэн байна.

Зураг 11 Хувьцаат капиталын бүтэц сүүлийн 5 жилийн байдлаар /тэрбум төгрөгөөр/



1.9 тэрбум төгрөг ба түүнээс дээш хувь нийлүүлсэн хөрөнгөтэй 373 ББСБ-ын хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ нийт хувь нийлүүлсэн хөрөнгийн 93.4% буюу 1.2 их наяд төгрөг байна. Харин 1.9 тэрбум төгрөг хүртэлх хувь нийлүүлсэн хөрөнгөтэй 149 ББСБ-ын 86.5 тэрбум төгрөгийн хувь нийлүүлсэн хөрөнгө салбарын нийт хувь нийлүүлсэн хөрөнгийн 6.8 хувийг бүрдүүлж байна. Салбарын хамгийн өндөр активтай 20 ББСБ-ын хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ 250.9 тэрбум төгрөг байгаа нь нийт хувь нийлүүлсэн хөрөнгийн 19.7 хувийг, бусдаас татан төвлөрүүлсэн эх үүсвэрийн дүн 972.3 тэрбум төгрөг байгаа нийт дүнгийн 76.2 хувийг бүрдүүлж байгаа зэргээс харахад томоохон ББСБ-ууд бусдаас хөрөнгө татан төвлөрүүлж үйл ажиллагаагаа явуулж байгаа тул хяналт шалгалтыг сайжруулах нь зүйтэй.

Хүснэгт 34 ХНХ-ийн интервал /тэрбум төгрөгөөр/

Интервал	Нийт		Эзлэх хувь		Дархан, Эрдэнэт		Бусад аймаг, сумд		ЗГВА	
	ХНХ	ББСБ тоо	Актив	ББСБ тоо	ХНХ	ББСБ тоо	ХНХ	ББСБ тоо	ХНХ	ББСБ тоо
5.0 тэрбумаас дээш	368.7	30	28.9%	5.7%	7.3	1	-	-	-	-
2.5-5.0 тэрбум	474.0	166	37.2%	31.8%	2.5	1	6.2	2	5.5	2
1.9-2.5 тэрбум	346.3	177	27.2%	33.9%	-	-	1.9	1	-	-
1.4-1.9 тэрбум	46.6	33	3.7%	6.3%	2.8	2	4.2	3	1.4	1
0.6-1.4 тэрбум	14.9	19	1.2%	3.6%	5.4	8	5.7	7	2.9	3
0.6 тэрбум хүртэлх	25.0	97	2.0%	18.6%	1.4	3	13.2	62	10.4	32
НИЙТ	1,275.5	522	100.0%	100.0%	19.4	15	31.2	75	20.1	38

Бусад өмч, сангууд

Бусад өмч өмнөх оны мөн үеэс 14.5 хувиар буурч 61.0 тэрбум төгрөгт, сангууд 2.7 дахин өсөж 2.7 тэрбум төгрөгт хүрсэн байна.

Хүснэгт 35 Бусад өмч, сангуудын бүтэц /сая төгрөгөөр/

	Дүн	Итгэлцэл	Уламжлалт	Финтек	ЗГВА	УБ	ХОН	ХК	ХХК	ГХО
Бусад өмч	60,994.4	54,413.0	46,750.2	14,244.2	309.7	60,640.8	353.6	52,281.8	8,712.6	40,422.0
Нэмж төлөгдсөн капитал	52,716.5	48,297.6	44,609.8	8,106.6	279.9	52,532.4	184.0	47,617.5	5,099.0	40,417.1
Дахин үнэлгээний нэмэгдэл	6,108.1	5,374.1	741.1	5,367.0	-	6,072.8	35.3	4,607.0	1,501.1	4.9
Хандивын капитал	2,169.8	741.3	1,399.2	770.6	29.7	2,035.6	134.2	57.3	2,112.5	-
Сангууд	2,690.1	1,109.3	2,669.2	20.9	-	1,928.7	761.3	19.3	2,670.8	15.9
Нөөцийн сан	2,163.4	1,074.0	2,163.4	-	-	1,633.3	530.1	-	2,163.4	14.9
Нийгмийн хөгжлийн сан	526.7	35.3	505.8	20.9	-	295.5	231.2	19.3	507.4	1.0

Хуримтлагдсан ашиг

Хуримтлагдсан ашиг өмнөх оны мөн үеэс 41.8% буюу 210.8 тэрбум төгрөгөөр өсөж 714.9 тэрбум төгрөгт хүрчээ.

Тайлант хугацаанд 438 ББСБ 241.4 тэрбум төгрөгийн ашигтай ажилласан бол 7 ББСБ үйл ажиллагаа эрхлээгүй, 77 ББСБ 6.3 тэрбум төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

Хүснэгт 36 Хуримтлагдсан ашиг/алдагдал /тэрбум төгрөгөөр/




Хоёрдогч өглөг

Өмнөх оны мөн үетэй харьцуулахад хоёрдогч өглөгийн хэмжээ 1.6 дахин өсөж 70.5 тэрбум төгрөгт хүрчээ. Энэхүү өсөлтийн 96.5 хувийг шинээр хоёрдогч өглөгөөр эх үүсвэр татсан 4 ББСБ-ын 60.2 тэрбум төгрөгийн хоёрдогч өглөгийн өсөлт бүрдүүлж байна. 2022 оны III улирлын байдлаар 6 ББСБ 70.5 тэрбум төгрөгийн хоёрдогч өглөгийн үлдэгдэлтэй байна.

Ашигт ажиллагаа

2022 оны III улирлын байдлаар ББСБ-ууд 624.8 тэрбум төгрөгийн орлого олж, 389.8 тэрбум төгрөгийн зардал гаргаж 235.0 тэрбум төгрөгийн ашигтай ажилласан байна.

Зураг 12 Ашигт ажиллагааны үзүүлэлт /тэрбум төгрөгөөр/



Өмнөх оны мөн үеэс орлогын хэмжээ 76.4% буюу 270.6 тэрбум төгрөгөөр, зардлын хэмжээ 88.8% буюу 183.4 тэрбум төгрөгөөр, ашгийн хэмжээ 59.0% буюу 87.3 тэрбум төгрөгөөр тус тус нэмэгдсэн байна.

Хүснэгт 37 Орлого, үр дүнгийн тайлан /харьцуулсан, сая төгрөгөөр/

ОРЛОГО	2021-III	2022-III	Нийт дүнд эзлэх хувь	Өөрчлөлт	
				Дүн	Хувь
Хүүгийн орлого	282,500,282.8	500,568,765.0	80.1%	218,068,482.2	77.2%
Хүүгийн бус орлого	63,437,752.0	110,049,297.7	17.6%	46,611,545.7	73.5%
- Санхүүгийн үйлчилгээний орлого	52,393,275.4	62,258,252.9	10.0%	9,864,977.4	18.8%
- Итгэлцлийн үйлчилгээний орлого	13,801.2	57,896.3	0.0%	44,095.0	319.5%
- Мөнгөн гуйвуулгын орлого	2,234,398.3	1,898,902.2	0.3%	-335,496.1	-15.0%
- Картын үйлчилгээний орлого	1,323,935.0	327.8	0.0%	-1,323,607.3	-100.0%
- Санхүүгийн зөвлөгөө, мэдээлэл өгөх үйлчилгээний орлого	149,555.2	44,570.9	0.0%	-104,984.3	-70.2%
- Үйлчилгээний хураамж, шимтгэлийн орлого	30,109,480.9	46,715,328.6	7.5%	16,605,847.7	55.2%
- Бусад	18,562,104.9	13,541,227.3	2.2%	-5,020,877.6	-27.0%
Үндсэн бус үйл ажиллагааны орлого	8,202,427.9	13,929,748.9	2.2%	5,727,321.1	69.8%
Ердийн бус орлого	51,450.5	261,619.2	0.0%	210,168.7	408.5%
НИЙТ ОРЛОГО	354,191,913.1	624,809,430.7	100.0%	270,617,517.6	76.4%
ЗАРДАЛ					
Хүүгийн зардал	30,291,016.2	68,630,821.1	17.6%	38,339,804.9	126.6%
Хүүгийн бус зардал	129,009,670.5	234,897,617.7	60.3%	105,887,947.2	82.1%
Болзошгүй эрсдэлийн зардал	29,294,693.0	51,903,841.4	13.3%	22,609,148.4	77.2%
Үндсэн бус үйл ажиллагааны зардал	2,875,671.7	4,940,762.7	1.3%	2,065,091.0	71.8%
Орлогын албан татварын зардал	14,921,890.3	29,370,298.2	7.5%	14,448,407.9	96.8%
Ердийн бус зардал	2,396.7	18,324.5	-	15,927.8	664.6%
НИЙТ ЗАРЛАГА	206,395,338.5	389,761,665.6	100.0%	183,366,327.2	88.8%
АШИГ					
ЦЭВЭР АШИГ	147,796,574.7	235,047,765.1	100.0%	87,251,190.4	59.0%

Өмнөх оны мөн үеэс хамгийн их өөрчлөлт орсон үзүүлэлтийг харвал орлогын хувьд итгэлцлийн үйлчилгээний орлого 4.2 дахин буюу 44.1 тэрбум төгрөгөөр өсжээ. Цар тахалтай холбоотойгоор сүүлийн 2 жилийн хугацаанд ББСБ-уудын ашигт ажиллагаанд төдийлөн өсөлт байхгүй байсан бол 2022 оны III улирлын байдлаар ББСБ-уудын үндсэн үйл ажиллагаа болох зээл олголт нэмэгдэж, үүнийгээ дагаад хүүгийн орлого болон үйлчилгээний хураамж шимтгэлийн орлого харгалзан 77.2% болон 55.2 хувиар тус тус нэмэгдсэн байна. /Үйлчилгээний хураамж шимтгэлийн орлогын дийлэнх хувийг бага дүнтэй, богино хугацаатай, хүүгүй онлайн зээл олгож буй ББСБ-уудын үйлчилгээний шимтгэлийн дүн бүрдүүлж байна/.

ББСБ-ын ердийн үйл ажиллагаанаас илт ялгаатай үйл явдал, ажил гүйлгээнээс үүсдэг байнга давтагдан гарахгүй орлого ба зардлыг ердийн бус орлого, зарлага гэдэг. Тухайлбал

байгалийн гамшиг болон гэнэтийн ослоос үүссэн давагдашгүй хүчин зүйлийн гарз хохирол, бэрхшээлтэй өрийн шинэчлэл зэрэг болно.

Ердийн бус орлогын хэмжээ өмнөх оны мөн үеэс 5.1 дахин өсөж 261.6 тэрбум төгрөгт хүрсэн байна Тайлант хугацаанд энэ ердийн бус орлого дансанд үлдэгдэлтэй гарсан 12 ББСБ, ердийн бус зарлага дансанд үлдэгдэлтэй гарсан 7 ББСБ-ын тайланг тодруулах шаардлагатай.

Хүснэгт 38 Орлого, үр дүнгийн тайлан /сая төгрөгөөр/

ОРЛОГО	Нийт	Итгэлцэл	Уламжлалт	Финтек	ЗГВА	УБ	ХОН	ХК	ГХО
Хүүгийн орлого	500,568.8	296,464.1	283,071.8	217,496.9	-	491,776.7	8,792.0	56,761.2	65,354.4
Хүүгийн бус орлого	110,049.3	73,606.2	58,307.9	51,741.3	2,063.8	109,256.6	792.7	31,592.8	15,149.6
- Санхүүгийн үйлчилгээний орлого	62,258.3	45,808.6	30,314.2	31,944.1	-	61,546.7	711.6	29,536.0	12,233.7
<i>Итгэлцлийн үйлчилгээний орлого</i>	57.9	57.9	-	57.9	-	57.9	-	-	-
<i>Мөнгөн гуйвуулгын орлого</i>	1,898.9	273.6	1,666.2	232.7	-	1,898.9	-	232.7	-
<i>Картын үйлчилгээний орлого</i>	0.3	-	0.3	-	-	0.3	-	-	-
<i>Санхүүгийн зөвлөгөө, мэдээлэл өгөх үйлчилгээний орлого</i>	44.6	44.6	0.1	44.5	-	44.6	-	44.5	-
<i>Үйлчилгээний хураамж, шимтгэлийн орлого</i>	46,715.3	40,420.1	17,749.0	28,966.3	-	46,069.4	646.0	28,177.4	11,750.3
<i>Бусад</i>	13,541.2	5,012.4	10,898.6	2,642.7	-	13,475.6	65.6	1,081.3	483.4
Үндсэн бус үйл ажиллагааны орлого	13,929.7	6,196.7	12,214.3	1,715.4	1.8	13,408.5	521.3	1,139.9	1,406.9
Ердийн бус орлого	261.6	-	261.6	-	-	243.6	18.0	-	-
НИЙТ ОРЛОГО	624,809.4	376,267.0	353,855.7	270,953.7	2,065.6	614,685.3	10,124.1	89,493.9	81,910.9
ЗАРДАЛ									
Хүүгийн зардал	68,630.8	47,622.1	29,721.8	38,909.0	-	68,229.0	401.8	12,188.4	9,717.8
Хүүгийн бус зардал	234,897.6	148,394.2	119,748.1	115,149.5	1,097.3	231,347.6	3,550.1	38,413.0	33,533.4
Болзошгүй эрсдэлийн зардал	51,903.8	30,137.3	26,498.6	25,405.2	-	51,273.4	630.5	8,661.3	7,208.7
Үндсэн бус үйл ажиллагааны зардал	4,940.8	1,917.1	3,294.6	1,646.1	1.0	4,863.3	77.4	634.9	751.4
Орлогын албан татварын зардал	29,370.3	19,320.5	19,163.0	10,207.3	27.7	29,015.8	354.5	5,703.7	5,876.0
Ердийн бус зардал	18.3	5.0	18.3	-	-	17.8	0.5	-	-
НИЙТ ЗАРЛАГА	389,761.7	247,396.1	198,444.5	191,317.2	1,126.0	384,746.8	5,014.9	65,601.4	57,087.4
АШИГ									
ЦЭВЭР ОРЛОГО	235,047.8	128,870.9	155,411.2	79,636.5	939.6	229,938.5	5,109.2	23,892.5	24,823.6

Зардлын хувьд өмнөх оны мөн үеэс хамгийн их өсөлт үзүүлсэн нь хүүгийн зардал болон ердийн бус зардал байна. Хүүгийн зардал болон ердийн бус зардал харгалзан 2.3 болон 7.6 дахин өсжээ. Хүүгийн зардлын өсөлтийн 74.5 хувийг банк, санхүүгийн байгууллагаас авсан зээлийн хүүгийн зардлын өсөлт бүрдүүлж байна.


Мөн өрийн бичгийн хүүгийн зардал 2.2 дахин буюу 11.6 тэрбум төгрөгөөр өссөн бол хүүгийн зардлын буцаалт 30.8 дахин буюу 1.6 тэрбум төгрөгөөр өсөж 1.7 тэрбум төгрөгт хүрчээ.

Гадаад валют арилжааны мэдээ

Тайлант улиралд гадаад валютын арилжааны тусгай зөвшөөрөлтэй 140 ББСБ-аас 72.8% буюу 102 ББСБ-аас ирүүлсэн тайлангаар 3,692.0 тэрбум төгрөгийн валют худалдан авч 3,912.5 тэрбум төгрөгийн валют зарсан байна.

2022 оны 5, 6 сард доллар, юань, евро, иений арилжаа огцом нэмэгдсэн байна.

Хүснэгт 39 2022 оны III улирлын байдлаарх валют арилжааны мэдээ /тэрбум төгрөгөөр/



Зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүд

2022 оны III улирлын санхүүгийн тайлангийн нэгтгэлийн дүнгээр 522 ББСБ-ын 90.2% буюу 471 ББСБ үйл ажиллагааны ЗХШҮ-үүдийг бүрэн хангаж ажилласан байна.

Нийт ББСБ-уудын 9.8% нь буюу 51 ББСБ-ын зохистой харьцаа алдагдсан байна. Үүнд: 1 зохистой харьцааг хангаагүй 45 ББСБ, 2 зохистой харьцааг хангаагүй 4 ББСБ, 4 зохистой харьцааг хангаагүй 1 ББСБ, 6 зохистой харьцааг хангаагүй 1 ББСБ байна.

Хүснэгт 40 ЗХШҮ /үзүүлэлт бүрээр/

№	Зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүд	Итгэлцэл /61 ББСБ/		Итгэлцэл, ГВА-аас бусад /423 ББСБ/		ЗГВА /38 ББСБ/		Нийт /522 ББСБ/		
		√	X	√	X	√	X	√	X	
1.	Нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө, эрсдэлээр жигнэсэн нийт активын харьцаа	61	-	421	2	38	-	520	2	
2.	Өөрийн хөрөнгө, эрсдэлээр жигнэсэн нийт активын харьцаа	61	-	421	2	38	-	520	2	
3.	Нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө, нийт активын харьцаа	61	-	420	3	38	-	519	3	
4.	Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа	57	4	410	13	37	1	504	18	
5.	Хөрөнгө /актив/-ийн эрсдэлийн сангийн хүрэлцээ (+илүү,- дутуу)	61	-	423	-	38	-	522	-	
6.	Нэг зээлдэгч болон холбогдох этгээдэд олгосон зээл, зээлтэй адилтган тооцох бусад актив хөрөнгө, төлбөрийн баталгааны зохистой харьцаа	61	-	414	9	XXX		513	9	
7.	ББСБ-аас гаргасан төлбөрийн баталгааны зохистой харьцаа	61	-	423	-				522	-
8.	ББСБ-ын хувьцаа эзэмшигч, ТУЗ, гүйцэтгэх захирал ажилтан холбогдох этгээдэд олгосон зээл, зээлтэй адилтган тооцох бусад актив хөрөнгө, төлбөрийн баталгааны нийлбэр дүнгийн зохистой харьцаа	61	-	422	1				521	1
9.	ББСБ-ын хувьцаа эзэмшигч, ТУЗ, гүйцэтгэх захирал ажилтан, холбогдох нэг этгээдэд олгосон зээл, зээлтэй адилтган тооцох бусад актив хөрөнгө, төлбөрийн баталгааны зохистой харьцаа	60	1	422	1				520	2
10.	Үнэт цаасны эзэмшил өөрийн хөрөнгийн зохистой харьцаа	61	-	423	-				522	-
11.	Компанийн хувьцаа, өөрийн хөрөнгийн зохистой харьцаа	61	-	423	-				522	-
12.	Монголын хөрөнгийн биржийн “Г”, “П” ангиллын нэг компанийн гаргасан хувьцаанаас худалдаж авах зохистой харьцаа	61	-	423	-				522	-
13.	Компанийн өрийн бичиг өөрийн хөрөнгийн зохистой харьцаа	61	-	423	-				522	-
14.	Бусад үнэт цаас, үнэт цаасны эзэмшлийн зохистой харьцаа	61	-	422	1				521	1
15.	Гадаад актив, пассивын зөрүү өөрийн хөрөнгийн зохистой харьцаа	60	1	413	10				511	11
16.	Итгэлцлийн үйлчилгээний өглөг өөрийн хөрөнгийн зохистой харьцаа	61	-	XXX					527	522
17.	Өрийн бичгийн зохистой харьцаа	61	-	423	-				522	-
18.	Үндсэн хөрөнгийн зохистой харьцаа	60	1	410	13		38	-	508	14

Тайлбар: √ - ЗХШҮ хангасан ББСБ-ын тоо
X - ЗХШҮ хангаагүй ББСБ-ын тоо

ББСБ-уудын хангах ёстой ЗХШҮ-үүдээс төлбөр түргэн гүйцэтгэх чадварын зохистой харьцааг хамгийн олон буюу 18 ББСБ, үндсэн хөрөнгийн зохистой харьцааг 14 ББСБ, гадаад актив, пассивын зөрүү өөрийн хөрөнгийн зохистой харьцааг 11 ББСБ тус тус хангаагүй буюу хамгийн их алдагдсан байна.

Бусдаас эх үүсвэр татан төвлөрүүлсэн, төлбөр түргэн гүйцэтгэх чадварын зохистой харьцаа алдагдсан 18 ББСБ-ын хяналтыг сайжруулж, анхаарч ажиллах шаардлагатай байна.

Дүгнэлт

2022 оны III улирлын байдлаар тайлан мэдээг ирүүлбэл зохих 522 ББСБ-аас 502 ББСБ тайлан мэдээг зохих ёсоор бүрэн ирүүлснийг холбогдох журмын дагуу хянаж, тайлангийн нэгтгэлд хамруулсан нэр бүхий 20 ББСБ өмнөх үеийн тайлан тэнцлээр нэгтгэлд хамрагдлаа. 2022 оны III улирлын байдлаар давхардсан тоогоор 23,143 хувьцаа эзэмшигчдийн 522 ББСБ, 419 салбар нэгж, 8 төлөөлөгчийн газар, 4,478 ажилтантайгаар Монгол улсын 21 аймаг, 8 дүүрэгт давхардсан тоогоор 4.9 сая харилцагч, 1.6 сая зээлдэгчид хүрч үйлчилж байна.

ББСБ-уудын нэгтгэлийн танилцуулгыг боловсруулах явцад бусдаас итгэлцэл болон өрийн бичиг хэлбэрээр эх үүсвэр татсан ББСБ-уудын тухайн үйлчилгээний харилцагчдын тоо нь статистик мэдээлэл болон тухайн тайлангийн дэлгэрэнгүй хэсэгт бөглөсөн тоо мэдээнээс зөрөх, тусгай зөвшөөрөлгүй, тухайн үйлчилгээний үлдэгдэлгүй ББСБ-ууд холбогдох харилцагчдын тоог нөхөх, аппликэйшн ашиглан зээл олгож байгаа ББСБ-ууд “Зээл олголт эргэн төлөлт, зээлийн хүүгийн судалгааны тайлан”-г дутуу нөхсөнөөс үүдэн мэдээллийг дахин тодруулах шаардлага үүсэж байна. Мөн шинээр авч байгаа тоо мэдээг нөхсөн байдал тун хангалтгүй байсан тул тухайн тайлангуудын нэгтгэлийг танилцуулгад дурдаагүй болно.

Актив, пассивын бүтэц

ББСБ-уудын нийт активын хэмжээ өмнөх оны мөн үеэс 40.6 хувиар өсөж, банкны салбарын 7.5%-тай тэнцэж байна. Харин хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ банкны салбарын 76.8%-тай тэнцэж байгаа нь өмнөх оны мөн үеүдтэй харьцуулахад 50.9 пунктээр буурсан дүн юм. Энэ нь ББСБ-уудын бусдаас татан төвлөрүүлж буй эх үүсвэрийн хэмжээ нэмэгдэж байгааг харуулж байна.

ББСБ-уудын нийт активын хэмжээ өмнөх оны мөн үеэс 38.2 хувиар өсөж, банкны салбарын 8.2%-тай тэнцэж байна. Харин хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ банкны салбарын 80.5%-тай тэнцэж байгаа нь өмнөх оны мөн үеүдтэй харьцуулахад 20.0 пунктээр буурсан дүн юм. Энэ нь ББСБ-уудын бусдаас татан төвлөрүүлж буй эх үүсвэрийн хэмжээ нэмэгдэж байгааг харуулж байна.

2022 оны III улирлын байдлаар банк бус санхүүгийн байгууллагын салбарын нийт хөрөнгө өмнөх оны мөн үеэс 38.2 хувиар буюу 940.7 тэрбум төгрөгөөр өсөж 3.4 их наяд төгрөгт хүрсэн байна. Активын өсөлтийн 93.0 хувийг цэвэр зээлийн өсөлт, пассивын өсөлтийн 53.0 хувийг өр төлбөрийн өсөлт, 47.0 хувийг өөрийн хөрөнгийн өсөлт бүрдүүлж байна.

ББСБ-ууд нь ихэвчлэн өөрийн хөрөнгөд тулгуурлан үйл ажиллагаа эрхэлдэг онцлогтой байсан хэдий ч сүүлийн 2 жилийн хугацаанд бусдаас итгэлцэл, өрийн бичиг, дотоод, гадаадын банк санхүүгийн байгууллага, төсөл хөтөлбөр хэлбэрээр эх үүсвэр татах нь нэмэгдэж байгаа тул тэдгээр /132 ББСБ/ ББСБ-уудын тайлан мэдээнд онцгой анхаарал хандуулах шаардлагатай гэж үзэж байна. Мөн дотоод, гадаад банк санхүүгийн байгууллагаас авсан зээл дансанд хувь хүн, санхүүгийн бус хуулийн этгээдээс эх үүсвэр татан төвлөрүүлж байгаа ББСБ-ууд нь эх үүсвэрийн зардлыг нэмэгдүүлж байгааг анхаарах шаардлагатай байна.

Тайлант улиралд богино хугацаат санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулалт хийх тусгай зөвшөөрөлтэй 22 ББСБ бүртгэлтэй байгаа хэдий ч 25 ББСБ санхүүгийн тайлангаар богино хугацаат хөрөнгө оруулалтын үлдэгдэлтэй гарсан ба эдгээрийн 12 ББСБ нь тусгай зөвшөөрөлтэй байна.

Засгийн газрын бондыг эрсдэлгүй гэж үзэн СЗХ-оос тухайн төрлийн бондыг тусгай зөвшөөрөлгүйгээр авах боломжтой гэж үзсэн хэдий ч санхүүгийн тайлангийн Засгийн газрын үнэт цаас хэсэгт бүртгэсэн дүн байхгүй байна. Иймээс 13 ББСБ тусгай зөвшөөрөлгүй энэхүү үйл ажиллагааг эрхэлсэн байгаа тул холбогдох арга хэмжээг авч ажиллах шаардлагатай байна.

Нийт зээлийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 51.0% буюу 900.2 тэрбум төгрөгөөр өсөж 2022 оны III улирлын байдлаар 2,666.1 тэрбум төгрөгт хүрсэн бөгөөд үүнд 142.1 тэрбум төгрөгийн эрсдэлийн сан байгуулж, 2,524.0 тэрбум төгрөгийн цэвэр зээлийн үлдэгдэлтэй гарсан байна. Нийт зээлийн үлдэгдлийн 88.5 хувийг буюу 2.4 их наяд төгрөгийг хэвийн зээл, 4.2 хувийг буюу 111.1 тэрбум төгрөгийг анхаарал хандуулах зээл, 7.3 хувийг буюу 194.7 тэрбум төгрөг чанаргүй зээлийн үлдэгдэл бүрдүүлж байна.

Нийт зээлд эзлэх хэвийн болон чанаргүй зээлийн хэмжээ өмнөх оны мөн үеэс харгалзан 0.3, 1.0 пунктээр тус тус буурсан бол чанаргүй зээлийн хэмжээ 1.3 пунктээр өссөн байна. Анхаарал хандуулах болон чанаргүй зээлийн 305.8 тэрбум төгрөгийн үлдэгдлийн 46.5%-д буюу 142.1 тэрбум төгрөгийн зээлийн эрсдэлийн сан байгуулсан байна.

Салбарын нийт пассив өмнөх оны мөн үеэс 38.2 хувиар буюу 940.7 тэрбум төгрөгөөр өссөн ба энэхүү өсөлтийн 53.0 хувийг өр төлбөрийн өсөлт, 47.0 хувийг өөрийн хөрөнгийн өсөлт бүрдүүлж байна. ББСБ-ын салбар нь 2022 оны III улирлын байдлаар итгэлцлийн үйлчилгээний өглөг 63.5 хувиар, дотоод, гадаадын банк, санхүүгийн байгууллагад төлөх өглөг 85.9 хувиар, ББСБ-аас гаргасан өрийн бичгийн үлдэгдэл 72.2 хувиар өссөн байгаа нь ББСБ-уудын хувьд бусдаас өртөг бүхий эх үүсвэрийг татан төвлөрүүлж байгааг харуулж байна. Мөн хоёрдогч өглөгийн хэмжээ 55.6 хувиар өсөж 70.5 тэрбум төгрөгт хүрчээ.

Ашигт ажиллагаа

2022 оны III улирлын байдлаар ББСБ-ууд 624.8 тэрбум төгрөгийн орлого олж, 389.8 тэрбум төгрөгийн зардал гаргаж 235.0 тэрбум төгрөгийн ашигтай ажилласан байна. Өмнөх оны мөн үеэс орлогын хэмжээ 76.4% буюу 270.6 тэрбум төгрөгөөр, зардлын хэмжээ 88.8% буюу 183.4 тэрбум төгрөгөөр, ашгийн хэмжээ 59.0% буюу 87.3 тэрбум төгрөгөөр тус тус нэмэгдсэн байна.

Цар тахалтай холбоотойгоор сүүлийн 2 жилийн хугацаанд ББСБ-уудын ашигт ажиллагаанд төдийлөн өсөлт байхгүй байсан бол 2022 оны III улирлын байдлаар ББСБ-уудын үндсэн үйл ажиллагаа болох зээл олголт нэмэгдэж, үүнийгээ дагаад хүүгийн орлого болон үйлчилгээний хураамж шимтгэлийн орлого харгалзан 77.2% болон 55.2 хувиар тус тус нэмэгдсэн байна.

Зохистой харьцааны шалгуур үзүүлэлт

2022 оны III улирлын санхүүгийн тайлангийн нэгтгэлийн дүнгээр 522 ББСБ-ын 90.2% буюу 471 ББСБ үйл ажиллагааны ЗХШҮ-үүдийг бүрэн хангаж ажилласан байна. Нийт ББСБ-уудын 9.8% нь буюу 51 ББСБ-ын зохистой харьцаа алдагдсан байна.

Алдагдсан зохистой харьцааны үзүүлэлтээс төлбөр түргэн гүйцэтгэх чадварын зохистой харьцааг хамгийн олон буюу 18 ББСБ, үндсэн хөрөнгийн зохистой харьцааг 14 ББСБ, гадаад актив, пассивын зөрүү өөрийн хөрөнгийн зохистой харьцааг 11 ББСБ тус тус хангаагүй буюу хамгийн их алдагдсан байна.

Бусдаас эх үүсвэр татан төвлөрүүлсэн, төлбөр түргэн гүйцэтгэх чадварын зохистой харьцаа алдагдсан 18 ББСБ-ыг хяналтыг сайжруулж, анхаарч ажиллах шаардлагатай байна.

БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГЫН ГАЗАР